

# ДЭЛГЭРЭНГҮЙ ДҮГНЭЛТ



**Бэлтгэгдсэн:** Meggan Doe | MeghanDoe@Hotmail.com

**Дуусгасан:** Даваа, 6 дугаар сар 5, 2023

**Хот:** Barquisimeto

**Зөвлөх:** demo consultant | demo\_consultant@staging.careerdirect-ge.org

КАРЬЕР ДИАРЕКТ ҮНЭЛГЭЭ НЬ ХҮНД ӨӨРИЙГӨӨ ТАНИХАД ТУСЛАХ ЗОРИЛГОТОЙ БӨГӨӨД ТӨРӨЛХИЙН ОНЦЛОГ, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СОНИРХОЛ, АВЪЯАС ЧАДВАР, ҮНЭТ ЗҮЙЛСЭЭ ТОДОРХОЙЛОХОД НЬ ТУСЛАХ ҮҮДНЭЭС БОЛОВСРУУЛАГДСАН ЮМ. ЭНЭХҮҮ СУДАЛГАА НЬ ХҮНД ОНОШ ТАВИХ, ЯЛГААТАЙ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ, СЭТГЭЛ ЗҮЙН БОЛООД ОЮУНЫ ЭМЧИЛГЭЭ ХИЙХ, ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД АШИГЛАГДАХ ЁСГҮЙ. ХЭРЭГЛЭГЧ КАРЬЕР ДИАРЕКТ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНД ҮНДЭСЛЭН ШИЙДВЭР ГАРГАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАРИУЦЛАГЫГ ДАНГААРАА ХАРИУЦНА. ТА КАРЬЕР ДИАРЕКТ ЦАХИМ ҮНЭЛГЭЭГ АШИГЛАСНААР КРАУН САНХҮҮГИЙН ҮЙЛЧЛЭЛ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ АЛИВАА КОМПАНИ, СУРГУУЛЬ, ТЭДГЭЭРИЙН АЖИЛЧДЫН ЭСРЭГ ЭНЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААР ЗАРГА, НЭХЭМЖЛЭЛ ҮҮСГЭХЭЭС ТАТГАЛЗАЖ БАЙНА ГЭСЭН ҮГ.

Краун Файнэншл Министриз, Корпораци. Карьер Диарект® онлайн хувилбарыг Краун Файнэншл Министриз боловсруулан гаргасан болно. Карьер Диарект ажил мэргэжлийн чиг олгох систем нь патенттай бүтээгдэхүүн; Карьер Диарект, Крауны лого, Краун санхүүгийн үйлчлэл, Крауны загвар зэрэг нь Краун Файнэншл Министриз байгууллагын (Краун санхүүгийн үйлчлэлийн) албан ёсоор бүртгүүлж эрх авсан бүтээгдэхүүнүүд юм. Бусад бүх бүтээгдэхүүн нь өөрсдийн хууль ёсны эзэмшигч нарын бүтээгдэхүүн болно.

# Агуулга

## Хэсэг 1 Хувийн мөн чанар

Хувийн мөн чанарын тухай ойлголт

- 1.1 Хувийн мөн чанарын зургаан хүчин зүйл
- 1.2 Хувийн мөн чанарын онцгой зүйлс
- 1.3 Давуу талууд
- 1.4 Давуу бус талууд
- 1.5 Амьдралын чухал асуудлууд

## Хэсэг 2 Ерөнхий сонирхол

Ерөнхий таван чухал сонирхлын талбар

- 2.1 Жагсаалтын эхний наймд багтсан ажил мэргэжил
- 2.2 Нийлбэр оноо
- 2.3 Эхэнд багтсан боломжит ажил мэргэжлийн жагсаалт

## Хэсэг 3 Ур чадвар ба чадамж

Ажил мэргэжил сонгоход тухайн талбарын ур чадварын гол шалгуур

- 3.1 Өндөр оноо бүхий 4 талбар
- 3.2 Өөрийн чадварыг дүгнэх

## Хэсэг 4 Үнэт зүйлс

Үнэт зүйлс нь ажил мэргэжлийн шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой.

- 4.1 Ажлын орчин
- 4.2 Ажлын үр дүн
- 4.3 Амьдралын үнэт зүйлс
- 4.4 Дүгнэлт

## Хураангуй

Хувийн мөн чанарын хураангуй

Сонирхол, авъяас чадвар, үнэт зүйлс, ажил мэргэжлийн товч дүгнэлт

## Хэсэг 5 Карьер Диарект – Дараагийн алхмууд

Карьер Диарект – Дараагийн алхмууд

## Хэсэг 6 Эх сурвалж

Эх сурвалж

# Дүгнэлтийг ашиглах зорилго:

## Ажил мэргэжлээ төлөвлөх



Meggan, Энэ дүгнэлтийг ашиглах үндсэн зарчим бол хүмүүс хийх ажлаа өөрсдийн мөн чанар, хүсэл сонирхол, ур чадвар, үнэт зүйлстэй холбож, ажилдаа сэтгэл хангалуун байж амжилтанд хүрэхэд оршино. Тиймээс эдгээр дөрвөн талбарт таны өгөх хариу нь ажил мэргэжлийн төлөвлөгөөгөө гаргахад тань үнэ цэнэтэй мэдээлэл болно. Ажил мэргэжлийн шийдвэр гаргахаасаа өмнө талбар бүрийг эргэцүүлж үзсэн байх ёстой.

Таны дүгнэлт танд тохирох ажлыг яг таг хэлж өгөхгүй. Харин танд өөрийн онцгой дүр төрхийг ойлгож мэдэхэд болон ямар төрлийн ажил танд тохирох талаар гол мэдээллүүдийг танд өгнө. Нэг хүний сонирхол ба бэлэг авьяаст тохирох ойролцоо шинж чанар бүхий олон ажлууд байж болох тул ийм ерөнхий хандлага нь хамаагүй дээр юм. Удирдамжийн системийн Карьер Диаректын® анкет хэсгийг ашигласнаар та хувилбаруудаасаа ажил мэргэжлийн сайн сонголт хүртэл сайжруулах боломжтой. Өөрийн авьяас чадвар, хүсэл сонирхлоо ашиглан ажил мэргэжлээ сонгох үйл явц нь танд одоо төдийгүй ирээдүйд ч ажил мэргэжилтэй холбоотой шийдвэрүүдэд туслах болно.

### ДҮГНЭЛТЭЭ САЙТАР ОЙЛГОХ НЬ ЧУХАЛ

Энэ дүгнэлтэд маш их мэдээлэл өгөгдсөн тул та үүнийг хэд хэд дахин унших хэрэг гарна. Мөн таны дүгнэлтийг тантай хамт унших найз, хань, халамжлагч гэх мэт хэн нэгэн байвал маш тустай байх болно. Ер нь хувийн мөн чанарын хувьд танаас ялгаатай хүн таны олж харж чадахгүй байгаа хэсгүүдийг ойлгоход онцгойлон тусалж чаддаг. Хэрвээ та ажил мэргэжлийн төлөвлөгөө гаргахдаа илүү тодорхой тусламж авахаар чиглүүлэгч зөвлөлтэй уулзахаар шийдсэн бол ажил мэргэжилтэй холбоотой өөрийн онцгой чадавхийн талаар ойлголттой болоход энэ дүгнэлт танд тусалж чадна. Өмнө дурдсанчлан, энэ дүгнэлтийг бүрэн дүүрэн ашиглахын тулд таны хамгийн чухал хийх алхам бол **өөрийн** КАРЬЕР ДИАРЕКТЫН СИСТЕМ дэх **Хэтийн төлөвлөгөөг** гаргаж хэрэгжүүлэх юм.

# Карьер Диаректын® цогц удирдамжийн системийн дүгнэлт


## ДҮГНЭЛТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дүгнэлт дөрвөн үндсэн хэсэгт хуваагддаг: Хувийн мөн чанар, ерөнхий сонирхол, ур чадвар, үнэт зүйлс. Эдгээр нь тус бүрдээ таны онцгой бүтэц, онцлогийн талаар чухал ойлголт мэдээлэлээр хангадаг. Дүгнэлтэнд буй бүх бүлгийн тодорхойлолтууд нь таны **КАРЬЕР ДИАРЕКТ УДИРДАМЖИЙН СИСТЕМИЙН** ажлын загвар хэсэгт байгаа.

- Хувийн мөн чанар** . Дүгнэлт нь хувийн мөн чанар хэсгээр эхэлдэг. Эндээс та, таны өвөрмөц чанарт үндэслэн гарсан хувийн мөн чанар, давуу ба сул талууд, ажлын орчин нөхцөл зэргээс зан чанарынхаа зургаан хүчин зүйлийн судалгааг олж харах боломжтой.
- Ерөнхий сонирхол** . Энэ хэсэгт ерөнхий сонирхлын 21 бүлэгт таны онооны жагсаалт болон таны сонирхол хамгийн өндөр байгаа ажил мэргэжлийн бүлгийн тодорхойлолтуудыг харах болно. Эдгээр өргөн хүрээг хамарсан ажил мэргэжлийн ангилалыг бүртгэл данс хэсгийн мэргэжлийн сонирхлууд хэсгээс гаргаж авсан. Таны оноонууд 21 сонирхлын бүлэг тус бүрийг та ямар түвшинд сонирхож байгааг харуулна. Мөн хүснэгтэд таны хамгийн их оноо бүхий найман сонирхол: хийх сонирхолтой зүйлс, сонирхдог ажил мэргэжлүүд, сэдвүүдийг харуулсан.
- Ур чадвар ба чадамж**. Энэ хэсэгт та өөрийн чадварыг 14 талбарт оноогоор нь жагсаасныг харах ба таны хамгийн хүчтэй чадвар, чадамжуудын тодорхойлолтуудыг харах болно.
- Үнэт зүйлс** . Энэ хэсэг нь гурван бүрэлдэхүүнтэй: ажлын орчин нөхцөл, ажлаас хүсч буй үр дүн, амьдралын үнэт зүйлс. Хэсэг тус бүрт таны хамгийн чухалд тооцсон дөрвөн зүйлийг онцлон харуулна.

### Оноо, үнэлгээг ойлгох нь

Хэсэг тус бүрийн хуваарьт хэмжүүр нь янз бүрийн талбарт амжилттай ажил эрхэлж буй олон тооны хүмүүсийн өгсөн хариунаас гаргаж авсан стандарчилан тогтоосон оноонд үндэслэсэн. Энд буй хуваарьт хэмжүүр нь танд авсан оноогоо бусад нийтлэг ажилчдын оноотой харьцуулан харах боломж олгоно. Хуваарьт хэмжүүр нь чиг хандлагыг тогтооход хялбар болгодог. Ашиглагдсан хэмжүүрүүдийн жишээг доор харууллаа.



Дээр өгөгдсөн графикт янз бүрийн хувийн мөн чанаруудыг харуулсан. Графикийн стандарт оноонууд нь +30-аас (зүүн) 0 хүртэл (дундаж), 0-ээс +30 (баруун) хүртэл (60 оноон дотор хэлбэлзэнэ) бөгөөд дундаж оноо нь 0 (дундаж түвшин) юм. Хүчин зүйл тус бүрийн хувьд, нийт хүмүүсийн ойролцоогоор гуравны нэг нь баруун (+6-аас +30), гуравны нэг нь дундаж (+5 зүүнээс 0, +5 баруун хүртэл), гуравны нэг нь зүүн (+6-аас +30) гэсэн оноо авдаг байна. Хуваарьт хэмжүүр дэх оноог тайлбарласныг доор үзнэ үү.



Дээрх жишээ бар графикт харуулсан оноонууд нь сонирхол, ур чадвар/чадваруудын оноо юм. Графикт хамгийн бага сонирхол (зүүн), дундаж сонирхол дундаж түвшин), хамгийн их сонирхол (баруун)-уудыг харуулсан. Эдгээр оноонууд нь гаргасан амжилтыг харуулахгүй бөгөөд "сайн" эсвэл "му" оноо биш юм. Эдгээр нь таны өгсөн хариултаудад үндэслэн бусад насанд хүрэгчид болон залуучуудтай харьцуулан таны үзүүлэлтийг гаргасан юм.

## Хэсэг 1: Хувийн мөн чанар

# Хувийн мөн чанарын тухай ойлголт


Meggan, Хувийн мөн чанар хэсэгт тухайн хүний төрөлхийн өдөөгдөн гаргадаг үйлдлийг тодорхойлно. Жишээ нь, зарим хүмүүс төрөлхийн маш эмх цэгцтэй, яв цав байхад нөгөө хэсэг нь цэгцтэй бус, энгийн хээгүй байдаг. Мөн түүнчлэн зарим хүмүүс эрсдэлтэй алхам хийдэг бол зарим нь төрөлхийн болгоомжлогчид байдаг.

Туршлага, ажиглалтаас харвал хамгийн шилдэг хувийн онцлог гэж байхгүй болох нь батлагдсан. Бүх хэв онцлогууд ижил үнэ цэнэтэй. Энэ нийгэмд болон ажлын байранд бүгд байх шаардлагатай бөгөөд бүгдэд нь давуу, сул тал гэж бий.

Хувь хүн ажил мэргэжилтэй холбоотой шийдвэр гаргахдаа өөрийн онцлог чанарыг харгалзан үзэх нь маш чухал юм. Гол зорилго нь таны төрөлх чиг хандлага, сонирхол, чадвар болон үнэт зүйлст хамгийн сайн тохирох ажил мэргэжлийг олж тогтоох юм. Дасгалжуулагч нарт янз бүрийн биеийн хэмжээ, хурд хүчтэй тамирчид хэрэгтэй байдагтай адил ажил олгогч нарт ч амжилттай баг бүрдүүлэхэд нь янз бүрийн онцлог чанартай хүмүүс хэрэгтэй байдаг.

### 1.1 Хувийн мөн чанарын зургаан хүчин зүйл

Энэ асуулга нь таны онцлог мөн чанарын зургаан чухал хүчин зүйлийг авч үзнэ:



Хувийн мөн чанарын тухайд дахин хэлэхэд, аль нэг төрлийн онцлог чанар нь нөгөөгөөсөө илүү дээр гэсэн зүйл огт байхгүй (ж/нь: гадагшаа, дотогшоо). Тухайн хүн өөрийн онцлогийн давуу талуудыг ашиглах хэрэгтэй.

Эдгээр хүчин зүйлсийг өргөн цар хүрээтэй судалгааны ажлын үндсэн дээр гаргаж ирсэн. Энэ хүчин зүйлс нь хувийн онцлогуудын бусад тогтсон хэмжүүртэй нийцэж байдаг.

Хүчин зүйл бүр нь зан байдлыг тодорхой хүрээнд харуулна. Жишээ нь, үнэлгээгээр гадагшаа чиглэсэн зан чанартай гэж тогтоогдсон хүмүүсийн хувьд танихгүй хүнтэй харилцахдаа дотогш чиглэсэн хүмүүсээс хамаагүй өөр байдаг. Энэ хоёрын дундуур үнэлэгдсэн хүмүүсийн хувьд ерөнхийдөө холимог зан үйлдэл үзүүлдэг. Та энэ хэсгийг уншихдаа хэмжигдэхүүн дээр буй бүх оноонууд нь давуу, сул талтай гэдгийг санах хэрэгтэй.

### ХУВИЙН МӨН ЧАНАРЫН ТАЛААРХ ДҮГНЭЛТЭЭ БАТЛАХ


Таны дүгнэлтийн хэсэг болон өөр бусад хэсгийг таны өгсөн хариултанд үндэслэн боловсруулсан. Тантай ойролцоо/ижил оноо авсан нэг төрлийн хүмүүсийн профайлтай ижил харагдана. Дүгнэлтүүд нь ихэнхи тохиолдолд оновчтой зөв байдаг ч зарим нэг зүйлс тантай таарахгүй байж болох тул та дүгнэлтээр харуулсан мэдээллийг бататган харах хэрэгтэй. Өөрийн тухай мэдлэгтээ үндэслэн дүгнэлттэй танилцахын зэрэгцээ өөрийн үнэлгээний хариуг зөв эсэхийг шалгахын тулд таныг сайн мэдэх өөр хүмүүсийн туслалцааг хүсээрэй. Таныг зөв тодорхойлж байгаа хэсгүүдэд илүү анхаарлаа хандуулаарай.

## 1.2 ТАНЫ МӨН ЧАНАРЫН ХҮЧИН ЗҮЙЛС, ДЭД ХҮЧИН ЗҮЙЛС

Meggan, Дараагийн гурван хуудсанд таны хувийн мөн чанарын зургаан хүчин зүйлийг жагсаасан байна. Тэдгээрийг хамгийн хүчтэйгээс хамгийн сул хүртэл дараалуулсан байгаа.

### 1. Адал явдалд дуртай

Эрсдэлтэй алхам хийдэг, зорилгынхоо төлөө тууштай зүтгэдэг, өрсөлдөх дуртай бөгөөд өөрийн чадварыг сорьсон ажилд татагддаг.



### Ажлын байрны онцлог

АДАЛ ЯВДАЛ/ЭРСДЭЛ хэсэгт өндөр оноо авсан тул таны хийх ажлууд дараах боломжуудыг багтаасан байх ёстой

- ✓ шинээр эхлүүлэх
- ✓ эрсдэлтэй алхам хийх
- ✓ өрсөлдөх
- ✓ томоохон зорилгуудад хүрэх
- ✓ адал явдалтай
- ✓ шинэ төслүүдийг эхлүүлэх

АДАЛ ЯВДАЛ/ЭРСДЭЛ хэсэгт авсан оноо таныг шинэ сорилт шалгууруудаар өдөөгддөг гэдгийг харуулж байна. Тодорхой эрсдэл дагуулсан ажилд оролцох нь танд харин ч таатай санагддаг. Аливааг цоо шинээр эхлүүлэх хүсэл чинь таныг шинэ талбарт ямар ч эргэлзээгүйгээр шилжин ороход хүргэдэг.


Таны гол давуу талуудын нэг бол маш их зоригтой, санаачлагатай чанар юм. Амжилт гүйцэтгэл таны хувьд маш чухал. Та өмнөө өндөр зорилго тавьж түүнд амжилттай хүрэхийн төлөө өөрийгөө дайчилдаг. Өсч дэвших эрмэлзэл ихтэй бөгөөд маш өрсөлдөөнч чанараасаа болоод таны хувьд харж, хэмжих боломжтой үр дүнг хүлээх нь хэвийн үзэгдэл байж болох. Магадгүй та туулж буй сорилт шалгуур бүртээ ялахыг хүсдэг байх.

Байж болзошгүй сул талууд нь ерөнхийдөө энэ төрөлтэй холбоотой давуу талуудыг хэтрүүлснээс үүдэн гарах үр дагаварууд юм. Жишээлбэл, та хэтэрхий өрсөлдөх хандлагаасаа болоод өөрт чухал зүйлээ гүйцэлдүүлэхийн тулд, эсвэл ялахын тулд арга заль гаргах, бусдыг дарах үйлдэл хийж болзошгүй.

Мөн, төрөлхийн амжилтанд хүрэх чадвартаа итгэх итгэл чинь бүх зүйл дээр таны зөв гэсэн бодолд таныг хөтөлдөг байж болох юм. Тантай санал зөрж, асуудлын нөгөө талыг харуулж чадах зөвлөхүүдтэй байх нь шийдвэрээ зөв зохистой үнэлж цэгнэхэд тань туслана. Эцэст нь хэлэхэд, та өөрийн төрөлхийн зоримог чанга байдлаа анхаарал болгоомжтой хослуулж чадвал та илүү үр нөлөөтэй байж чадна.

### 2. Энэрэнгүй

Өрөвч энэрэнгүй, мэдрэмтгий, бөгөөд сайн сонсогч; тэвчээртэй, үнэнч, бусдыг дэмжих, зоригжуулахдаа сайн.



### Ажлын байрны онцлог

ЭНЭРЭНГҮЙ БАЙДАЛ хүчин зүйлд та харьцангуй өндөр оноо авчээ. Та, өдөр тутам хүмүүстэй нүүр тулж маргах юм уу, тэдний эсэргүүцэлтэй тулгарах шаардлага гарахааргүй ажлыг эрэлхийлэх нь зүйтэй. Бусадтай нөхөрсөг байдлаар харилцаж, тэдэнд туслалх боломжтой ажил танд илүү тохирно. Ажлын байр нь дараах нөхцлийг агуулах хэрэгтэй:

- ✓ Эелдэг байдал
- ✓ Хүлээцтэй байдал
- ✓ Итгэлцлийн түвшин өндөр
- ✓ Тогтвортой
- ✓ Эв найрамдалтай
- ✓ Бусдад туслалх боломжтой


ЭНЭРЭНГҮЙ чанар хэсэгт авсан оноо нь таныг энэрэнгүй, бусдыг ойлгодог нэгэн гэдгийг харуулж байна. Мэдрэмтгий чанар чинь таныг эргэн тойронд буй хүмүүсийнхээ зөрчил тэмцэл, өвдөлт шаналалд сонор соргог болгодог. Тэвчээртэй, шүүмжилдэггүй сонсогч байснаараа, ялангуяа нэг нэгээрээ хувьчилан ярилцах үед та бусдад маш гүн нөлөө үзүүлж чаддаг.

Хүмүүс таны чин сэтгэлийн анхаарал, халамжилж буй хандлагаас болоод аяндаа тантай хуваалцаж ярилцахыг хүсдэг. Ийм үед та мөн тэднийг зоригжуулж, зөвлөх нь таны төрөлхийн чадвар гэдгийг олж хардаг.

Бусадтай нийцтэй чанар чинь таныг эв нэгдэлтэй л байгаа бол бараг бүх л нөхцөл байдалд хялбархан дасан зохицоход тусладаг. Таны хувьд зөрчил маргаан дарамттай байдаг учраас ямар ч байгууллага, хамт олонтой нэгдэхээсээ өмнө тэднийг няхуур судлаж шалгахыг хүсдэг.

### 3. Шинийг санаачлагч

Маш бүтээлч. Та онцгойлон шинэ санаануудыг боловсруулж, илэрхийлэх дуртай бөгөөд оюуны хүч сорьсон зүйлсийг эрэлхийлдэг.



### Ажлын байрны онцлог

ШИННИЙГ САНААЧЛАГЧ хүчин зүйлд авсан онооноос тань үзвэл та хийх ажилдаа дараах боломжуудыг эрэлхийлэх хэрэгтэй:

- ✓ Бүтээлч байдлаа чөлөөтэй илэрхийлэх
- ✓ Оюуны хувьд сорьсон
- ✓ Санаануудтай ажиллах
- ✓ Бодох цаг
- ✓ Хийсвэр ойлголтууд
- ✓ Уран сайхан илэрхийлэх


Meggan, ШИННИЙГ САНААЧЛАГЧ хэсэгт авсан оноо чинь таныг маш бүтээлч нэгэн гэдгийг харуулж байна. Та шинэ санаа, шинэ шийдлийг бий болгохдоо гаргууд сайн. Хэдий тэдгээр санаа нь бусдад эгэл биш, гаж санагдсан ч хамаагүй. Магадгүй та маш их зүйлийг мөрөөдөж эсвэл ямар нэг санааны талаар өөр өөр өнцгөөс харан оюун бодлоо хөгжөөх дуртай. Та өөрийн бүтээлч байдлыг янз бүрээр илэрхийлдэг ба үүнд асуудлыг логик үндэстэйгээр шийдвэрлэх, гар урлал хийх, эсвэл зохиол бичих, хөгжим, жүжиг, зураг баримал гэх мэт өөр янз бүрийн урлагийн бүтээлүүд багтана.

Та мөн ухаалаг, түргэн сэтгэх чадвартай. Таны хувьд оюун ухаанаа сорьсон зүйлийг хийх нь хэвийн үзэгдэл байдаг. Та бодож сэтгэхийг яг л зугаацах мэт үзэн дурладаг бөгөөд таны оюун ухааны хувьд аливааг гүн хийгээд өргөн хүрээнд дүгнэн шинжлэх хялбар байдаг.

Бүтээлч зан, төсөөлөн бодох чадвар олон тохиолдолд чухал нөөц баялаг болдог ч шинэ санаануудыг ажил хэрэг болгохын тулд бодит алхам хийхгүй л бол эдгээр нь зүгээр нэг бодол, мөрөөдөл болж хувирна. Таны хувьд анхаарлаа төвлөрүүлж, эхэлсэн ажлаа тууштай үргэлжлүүлэх нь амар биш байдаг байж болох. Та магадгүй өдөр тутмын, бодит асуудлуудыг амархан мартдаг байж магад. Жагсаалт гаргах, ажлаа хийж дуусгах цаг тогтоох, хариуцлага тооцох тал дээр баттай зориулалт гаргах зэрэг нь таны үр бүтээлтэй байдлыг нэмэгдүүлэх болно.

#### 4. Гадагшаа

Гадагш чиглэсэн, шинэ хүмүүстэй уулзах дуртай төрөлхийн хүмүүс төвтэй нэгэн; та хүсэл тэмүүлэл дүүрэн бөгөөд бусадтай харилцаа холбоо тогтоохдоо сайн.



#### Ажлын байрны онцлог

ГАДАГШАА ЗАН БАЙДАЛД авсан онооноос тань үзвэл та хүмүүст чиглэсэн ажил үүргүүдэд хамгийн сайн тохирно. Хүмүүстэй нөхөрсөг харилцах боломж олгон дараах боломжуудаар таныг хангах ажлыг эрэлхийлээрэй:

- ✓ урамшуулах
- ✓ зоригжуулах
- ✓ гүйцэтгэх/толилуулах
- ✓ харилцааны сүлжээ тогтоох
- ✓ хошигнох

ГАДАГШАА ЗАН БАЙДАЛ хэсэгт авсан оноо чинь таныг хүмүүстэй ойр ойрхон уулзахыг эрмэлздэг, үг ярианы чадвар өндөр хөгжсөн нэгэн гэдгийг илэрхийлж байна. Таны бусадтай харилцахдаа гаргаж буй дохио зангаа, урам зоригтой байдал, байнгын инээмсэглэл чинь маш их эрч хүчтэй нэгэн гэдгийг илэрхий харуулдаг. Та бусдыг үнэмшүүлэх, ятган уриалах боломжуудаар хурцлагддаг бөгөөд олны дунд байхдаа хүмүүст эерэг сэтгэгдэл үлдээдэг.


Хүмүүсийг чухалчилдаг хүн учраас та уулзалт, конференц, дурсамж уулзалт, үдэшлэг гэх мэт олон нийтийн уулзалтуудад оролцож хүмүүстэй холбогдох боломжуудыг баяртайгаар хүлээж авдаг.

Таны өөр нэг давуу тал бол цаг үедээ тохируулан уян хатан байдаг бөгөөд аливаад баригддаггүй хэв маяг юм. Та огт бүрэг ичимхий биш бөгөөд та хэрхэн зожиг бүрэг хүмүүсийг багийн үйл ажиллагаанд илүү ихээр татан оруулахаа мэддэг. Олон хүний өмнө гарч үг хэлэх, толилуулга хийх боломжууд таныг илүү эрч хүчтэй болгодог.

Meggan, давуу тал хэтрэхээрээ сул тал болдог гэдгийг санах хэрэгтэй. Үг ярианы чадвар чинь таны жинхэнэ үнэт хөрөнгө мөн. Гэвч хэзээ нь чимээгүй байж сонсох хэрэгтэйгээ мэддэг байх нь мэргэн ухаан билээ. Бусад хүмүүс таны яриаг хэрхэн хүлээн авч байгаад мэдрэмжтэй хандах нь тэдний хүсэл сонирхол болон ярих хэрэгтэй байгаа зүйлсийн талаар илүү анхаарал тавихад тустай. Үр нөлөөтэй байдлаа хамгийн дээд хэмжээнд хүргэхийн тулд эргэн тойронд байгаа хүмүүсээ анхаарч, өөрийн биеэ авч явж буй байдлаа тухайн нөхцөл байдалд тохируулах нь чухал.

#### 5. Удирдангуй

Зоримог, өөртөө итгэлтэй, үр дүнг чухалчилдаг бөгөөд төрөлхийн удирдах хүсэл эрмэлзэлтэй.



#### Ажлын байрны онцлог

УДИРДАНГУЙ байх хүсэл эрмэлзлээ биелүүлэхийн тулд дараах боломжуудыг олгох ажил мэргэжлийг эрэлхийлээрэй:

- ✓ хариуцлагатай байр сууринд байх
- ✓ ирээдүйн төлөвлөгөө гаргадаг
- ✓ шулуухан ярьдаг
- ✓ шинэ санаануудыг хэрэгжүүлдэг
- ✓ бусдад нөлөөлдөг
- ✓ шийдвэр гаргадаг

Meggan, УДИРДАНГУЙ чанар хэсэгт авсан оноо чинь таныг төрөлхийн байгаа орчноо өөрийн хяналтанд байлгах дуртай хүн гэдгийг илэрхийлж байна. Энэхүү бусдыг нөлөөндөө байлгах хүсэл нь таны амьдралд олон зүйлээр дамжин илэрхийлэгдэж байсан байх. Та машин барьж, онгоц жолоодох, амралтаа төлөвлөж эсвэл ажил дээрээ эрэмбэ дараа тогтоож байх үедээ ч төрөлх чанараараа хэнээс ч илүү өөртөө итгэн, өөрөө бүгдийг хариуцан хянахыг хүсдэг. Та өөр хэн нэгний гаргасан хөтөлбөр төлөвлөгөөнд захирагдах шаардлагатай нөхцөл байдлаас та зайлсхийдэг болохоо та анзаарсан байх.




Өөртөө итгэлтэй, шийдэмгий мөн чанар чинь таныг удирдлагын байр сууринд маш сайн тохирно гэдгийг харуулдаг. Та төрөлхийн бусдад нөлөөлөх хүсэлтэй бөгөөд энэ нь таныг улс төрд, худалдааны салбарт болон эдгээртэй төстэй ажил мэргэжлүүдэд амжилтад хүрэхэд нөлөөлдөг. УДИРДАНГУЙ ЧАНАР хэсэгт өндөр оноо авсан ихэнх хүмүүс ерөнхийдөө "том зураглал" бүхий үзэл бодлын үүднээс ажиллах хандлагатай байдаг. Энэ нь танд өөрчлөлтийг урьдчилан таамаглах, ирээдүйд хэрхэн ажиллах талаар шинэ санаануудыг төсөөлөн тогтоох зэрэг онцгой чадварыг өгдөг. Энэхүү "алсыг харах" ур чадвар бол таны гол давуу талуудын нэг юм.

Та бусдаас тусгаар байх хүчтэй хүсэл эрмэлзэлтэй бөгөөд магадгүй аливааг хэрхэн хийх талаар өөрийн гэсэн үзэл бодолтой байдаг. Өөрийн санал бодол, шинэ санаануудыг илэрхийлж ярина гэдэг нь таны хувьд хэвийн үзэгдэл юм.

Бүхнийг хариуцагч мөн чанартангуудын хувьд түгээмэл байдаг сул талууд бий. Аливааг хяналтандаа байлгах хүслийнхээ улмаас та магадгүй хангалттай туршлага, мэдээлэл байхгүй ажлын талбаруудад ажиллах үе гардаг. Мөн, та өөрийн том зураглал бүхий санаагаа ажил хэрэг болгохын тулд шаардлагатай ажлын нарийвчилсан хэсгүүдийг хэт томруулж харах эсвэл дутуу тооцоолох хандлагатай байдаг гэдгээ санаж явах хэрэгтэй. Ерөнхийдөө илүү болгоомжтой хандлага, танаас эсрэг мөн чанар бүхий хүний эрүүл зөвлөгөөг сонсдог байх нь танд тустай.

## 6. Баригдмал биш / Нягт нямбай (Дундаж -түвшин)

Зарим зүйл дээр зохион байгуулалттай ч зарим зүйлсэд урсгалаараа тохируулж үйлддэг.



### Ажлын байрны онцлог

НЯГТ НЯМБАЙ хүчин зүйл дээр дундаж оноо авсан нь таныг бүтэц зохион байгуулалттай зүйлсд дуртай ч зарим зүйлс нь урсгалаараа аяндаа болох нь танд таалагддаг гэдгийг илтгэж байна. Та бэлэн байх дуртай боловч, шаардлагатай бол газар дээр нь хариултыг нь өгөхөд ч түүртэхгүй байж чаддаг. Янз бүрийн ажил мэргэжлийн талбаруудыг судлахдаа та тэнцвэртэй байдлыг хадгалж чадах, дараах шинжүүдийг агуулсан ажлын байруудыг эрэлхийлээрэй,

- ✓ **бүтэц зохион байгуулалттай гэхдээ хэт чанга хатуу биш**
- ✓ **тогтвортой гэхдээ зарим нэг өөрчлөлт хийгддэг**
- ✓ **Урьдаас мэдэх боломжтой боловч зарим үед тухайн цаг үед нь арга хэмжээ авах боломжууд гардаг**
- ✓ **Нарийн тодорхой боловч илүү өргөн цар хүрээтэй асуудлуудтай ажиллах боломжтой**

НЯГТ НЯМБАЙ чанар хэсэгт дундаж оноо авсан нь таныг нарийн няхуур ба хэнэггүй байдлын аль алинд нь чадвартайг харуулж байна. Та өөрийн амьдралын хэв маяг, ажлын зуршлуудаа шалган харвал зарим хэсэгт нь та маш сайн зохион байгуулалттай, нягт нямбай, алдаагүй зөв үйлддэг нь харагдана. Тэр ч бүү хэл та заримдаа өөрийн зарим арга барил, санаануудыг хамгаалан хөдөлшгүй зогсдог бөгөөд буулт хийх тухай бодохыг ч хүсдэггүй.

Хэдий тийм боловч өөр бусад талбаруудын хувьд та нэлээд хэнэггүй, аясаар нь ханддаг бөгөөд нарийн ширийн мэдээллийг бүр тоодог ч үгүй. Та магадгүй шинэ чиглэл рүү шилжихийн тулд бүтэц зохион байгуулалт, дүрэм журам болон тогтсон арга барилыг эсэргүүцэж ч болох юм.

Энэ хэмжигдэхүүний хувьд та тэнцвэртэй байж чаддаг тул амьдралд хэр зэрэг нягт няхуур ханддагийг чинь "янз бүр" гэдэг үг хамгийн сайн тодорхойлох болов уу. Таны гэнэтийн шийдвэрүүдийн давалгаа, сониуч занг чинь анхаарал болгоомж, түдгэлзэл тэнцвэржүүлэн барьдаг. Шалтгаан нь маш энгийн: Таны бодлоор, зарим нөхцөл байдал бусдаасаа илүү их анхаарал, болгоомжлол шаарддаг аж.

Та өөрийн уян хатан чанарыг онц сайн чанар, үр дүнд хүрэх тууштай зориулалттай хослуулснаар гайхамшигтай үр дүнг бий болгож чадна. Ялангуяа та зорилгоо бичиж тэмдэглэн түүнийгээ биелүүлэхийн тулд маш сайн бодож боловсруулсан төлөвлөгөө гаргавал танд тустай.

### 1.3 Давуу талууд

---

Meggan, Доорхи нь тантай ижил оноо авсан хүмүүсийн хувьд нийтлэг давуу талууд юм. Эдгээр хүчирхэг талуудаа тодруулан харуулах ажлын боломжуудыг эрэлхийлээрэй. Эдгээр давуу талаа ажлын байрандаа хэр их ашиглах боломжтой байна тэр хэрээр та амжилттай бөгөөд сэтгэл хангалуун байж чадна. Өмнө дурдсанчлан, таныг сайн мэдэх нэгэнтэй уулзаж энэ бүхэн таны хувьд үнэхээр таарч байгаа эсэхийг шалган бататгах хэрэгтэй.

- Удирдлагад төвлөрсөн; төрөлхийн бусдад нөлөөлөх болон хариуцлага хүлээх дур сонирхолтой
- Бусадтай харилцахдаа боловсон ёс суртахуунтай.
- Өөртөө найддаг; өөрийн чадварт бат итгэлтэй.
- Эрч хүчтэй, эерэг, бадрангуй тэмүүлэлтэй; олон үйл ажиллагаанд оролцох дуртай
- Гадагшаа чиглэсэн, бусадтай зохицоходоо сайн; шинэ хүмүүстэй уулзсанаар эрч хүчтэй болдог.
- Бусдыг зоригжуулахдаа сайн.
- Бусдад энэрэнгүй, өрөвч ханддаг.
- Найрсаг зантай, бусадтай зохицон ажиллахдаа сайн.
- Зорилгодоо хүрэх хатуу шийдвэртэй.
- Аливааг өргөн цар хүрээнд харж ажилладаг.
- Зорилгодоо хүрэх хүчтэй эрмэлзэлтэй, боломжуудыг эрэлхийлдэг; амжилтад хүрэх тэмүүлэл их.
- Шинийг эхлүүлэгч; тооцсон эрсдлийг хүлээх дуртай.
- Хүнд бэрх цаг үед тайван бөгөөд итгэлтэй байж чаддаг.
- Түргэн сэтгэдэг; хийсвэр ойлголтуудыг хүлээж авах чадвартай.
- Шийдлүүдийг боловсруулах болон асуудлуудад хариу үйлдэхдээ ухаалаг ханддаг
- Бүтээлч, төсөөлөн бодогч, уран сэтгэмжтэй; шинэ санаануудыг гаргахдаа сайн.

### 1.4 Давуу бус талууд


---

Доорхи чанарууд нь тантай ижил оноо авсан хүмүүст түгээмэл байдаг. Эдгээр талбаруудыг сайжруулснаар таны гүйцэтгэл илүү нэмэгдэх болно. Нөгөө талаас та өөрийн давуу талд ороогүй талбаруудад аль болох оролцохгүй байхыг хичээ. Өмнө дурдсанчлан, таныг сайн мэдэх нэгэнтэй уулзаж энэ бүхэн таны хувьд үнэхээр таарч байгаа эсэхийг шалган бататгах хэрэгтэй.

- Үр дүнд хүрэхийн тулд хэт шахамдуулах хандлагатай.
- Жинхэнэ үзэл бодлоо илэрхийлэхгүй байж магад.
- Амжилт ихэнхдээ багийн хамтын зүтгэл байдаг гэдгийг мартдаг.
- Гарах үр дүн болон хүмүүсийн талаар хэтэрхий өөдрөг хандлагатай.
- Цаг төлөвлөх, мөн ярианы сэдвээс гажихгүй төвлөрөх тал дээр дутагдалтай байх магадлалтай.
- Бусдад "үгүй" гэж хэлэхэд танд амаргүй байдаг.
- Хэт итгэмтгий, бусдад нөхцөл байдлыг давуугаар ашиглах боломж олгодог.
- Зөрчилдөөнөөс болж стресст ордог бөгөөд хүмүүстэй нүүр тулах дургүй.
- Ажилдаа хэт улайрнаас болоод эрүүл мэнд, гэр бүл болон бусдын хэрэгцээг үл тоомсорлож орхих магадлалтай.
- Чухал зүйлийг харахгүй өнгөрөх; хэтэрхий хурдан дүгнэлт рүү шилжин орох магадлалтай.
- Хувийн зорилгодоо хэт анхаарснаас болоод амжилтад хүрэхийн тулд гэр бүлээ золиослох хандлагатай.
- Шаардлагагүй эрсдлүүдийг үүрэх үе байдаг.
- Өөрийгөө дөвийлгөх хандлагатай байж магад.
- Тогтсон дүрэм журмын дагуу ажиллахаас амархан уйдаж залхдаг.

## 1.5 Амьдралын чухал асуудлууд

Энэ хэсэг нь таныг хувийн мөн чанарын давуу шинжүүдэд нийцсэн ажиллах орчин бүхий ажил мэргэжил сонгоход туслахуйц ойлголтыг өгнө.



### Стресс

СТРЕСС хэсэгт авсан оноо чинь таныг манай нийгмийн дундаж хүмүүстэй ижил түвшний стресстэй байгааг харуулж байна. Энэхүү үнэлгээ нь сэтгэл зүйн асуудлуудыг тодорхойлж эмчлэхийн тулд хийгдээгүй гэдгийг санаарай. Хэрэв зарим талбарт тусламж хэрэгтэй мэт санагдаж байгаа бол та оношлогоо шинжилгээ хийлгэхийн тулд тохирох мэргэжилтэнтэй холбоо тогтоогоорой.

### Өртэй

Таны хариуцуулсан таныг дунджаас дээгүүр түвшний өртэй гэдгийг харуулж байна. Орлогоо төсөвлөж, төсвийн хүрээнд зарцуулж, хадгалж амьдрах нь таныг энэ нөхцөл байдлаасаа гарахад туслах болно. Туршлагаас харвал ихэнх хүмүүсийн хувьд зориулалт гаргаж чадвал хэрэглээний зээлээ (байрны зээлээс бусад бүх зээл) таван жилээс доош хугацаанд төлж дуусгаж чаддаг.

### Санхүүгийн менежмент

Та санхүүгийн хувьд эрүүл зөв төлөвлөгөөтэй амьдарч байгаа гэж харагдаж байна. Та төсөв гарган зарцуулалтаа хянаж чаддаг бөгөөд тогтмол хадгаламж үүсгэж чаддаг төдийгүй ирээдүйд гарч болох гэнэтийн зардалд зориулсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөө хэрэгжүүлдэг.

# Ерөнхий таван чухал сонирхлын талбар

Meggan, Өөрийн ерөнхий хүсэл сонирхлыг нээж олох нь дараах энгийн шалтгааны улмаас ажил мэргэжлээ төлөвлөхөд нэн чухал үүрэгтэй: Хүмүүс хийж байгаа ажилдаа хүсэл сонирхолтой байвал ажилдаа амжилт гаргах хандлагатай байдаг! Нэг хүний хувьд уйтгартай, сонирхолгүй санагдаж байгаа ажил өөр нэгний хувьд төрөлхийн хийх дуртай ажил нь байдаг. Ерөнхийдөө, таны сонирхлыг татдаг ажил л бол хичнээн хэцүү, уйтгартай байсан ч танд хийхэд зугаатай хөгжилтэй байж чаддаг.


Таны төрөлхийн хүсэл сонирхлын улмаас амралт чөлөөт цагаараа хийдэг зүйлс таны ерөнхий сонирхлын оноонд нөлөөлөх магадлалтай. Иймд та дүгнэлтийнхээ ерөнхий сонирхол хэсгийг тайлж уншихдаа тодорхой хэмжээнд хянуур хандах хэрэгтэй гэсэн үг юм.

Жишээ нь, хэрэв та бие бялдраа чийрэгжүүлэх, спортоор хичээллэх дуртай бол "Спорт ба фитнес" нь карьерын бүлэгт өндөр оноотой гарч болох юм. Гэхдээ маш цөөхөн хүн мэргэжлийн тамирчны карьерт хүрдэг гэдгийг бодож, спорт фитнесийн өндөр оноогоо та ажил мэргэжил болгож биш харин чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлж бие бялдраа эрүүл байлгахад ашиглаж болох юм гэдгийг санаарай.

Нөгөө талаас, Meggan, Та ажлын талбараа өөрийн дуртай зүйлтэй хэр их холбож өгнө тэр хэрээрээ амжилттай байх магадлалтай байдаг. Нум сум харвах дуртай нэгэн өөрийн энэ сонирхлыг ажилтайгаа холбож нум сум үйлдвэрлэлийн тэргүүлэгч компаний шилдэг борлуулагч нарын нэг болсон байдаг. Үүнчлэн олон хүмүүс өөрийн хобби дээр үндэслэн амжилттай бизнес эрхлэгч нар болсон байдаг. Та хийж байгаа зүйлдээ дуртай байх тусам хийж буй ажилдаа сэтгэл хангалуун байж чадах бөгөөд таны ажлын стресс тэр хэрээрээ бага байх болно гэдгийг санаарай.

Ажил мэргэжлийн сонирхлыг ангилах хэд хэдэн арга бий. Энэ тайланд карьер сонирхлын таван том ерөнхий хэсэгт хуваагдсан 21 нарийвчилсан сонирхлын бүлгийг ашигладаг. Эдгээр таван гол карьер сонирхолын хэсгийг дугуй графикаар доор харуулав. Мөн энд таны Top 8 нарийвчилсан сонирхлын бүлгүүд нь таван том ерөнхий хэсэгтээ яаж харьяалагддагийг харуулж байна. Хэрэв таны карьер сонирхлын ерөнхий хэсэг таваас бага байвал, таны шилдэг 8 нарийвчилсан сонирхол тэдгээрт нь багтсан байдаг. Та дэлгэрэнгүй мэдээллийг дараах хуудсуудаас харж болно.

## Сонирхдог чиглэл, ажил мэргэжил



- Нөлөөлөх нь 51%
- Илэрхийлэх 25%
- Дүн шинжилгээ хийх 12%
- Тусламж 12%
- Хийх 0%

### Нөлөөлөх нь (51%)

- 1. Соёл дамжсан харилцаа (65)
- 4. Итгэл үнэмшил/Үйлчлэл ба омлол сургаал (55)
- 3. Хууль/Улс төр (55)
- 5. Боловсрол (53)

### Илэрхийлэх (25%)

- 2. Урлаг/дизайн (58)
- 7. Гүйцэтгэл/харилцаа холбоо (52)

### Дүн шинжилгээ хийх (12%)

- 8. Тооцоолол/Санхүү (52)






### Тусламж (12%)

- 6. Үйлчилгээ/Удирдлага зохион байгуулалт (53)

### Хийх (0%)

## Ерөнхий таван чухал сонирхлын талбар

Доорх график дээрх карьер сонирхлын таван ерөнхий хэсгээс 0% -ийг харуулсан ямар нэгэн хэсэг байгаа бол энэ нь таны Top 8 нарийвчилсан сонирхолын бүлгүүд тэр хэсэгт хамааралгүйтэй холбоотой юм. Гэсэн ч бусад хэсэгт хамаарах таны топ 8 нарийвчилсан сонирхол хэвээрээ байгааг харж болно.




## 2.1 Жагсаалтын эхний наймд багтсан ажил мэргэжил

Гурван бүрэлдэхүүн хэсэг болох Үйл ажиллагаа, Ажил мэргэжил, Боловсролын сэдвийн дагуу өөрийн карьер бүлгийн оноог тодорхойл. Эдгээр сонирхол нь ажил мэргэжил, чөлөөт цагтай холбоотой байж болно. Эсвэл таны ажил мэргэжилд дэм болох хобби сонирхол байж болно. Карьерын бүлгүүд нь хэд хэдэн хэсгээс бүрддэг. Нэг Activity бүлэг нь таны хувьд маш чухал болов ч бусад бүрэлдэхүүн хэсэг нь таны хувьд чухал биш байж болох юм. Иймээс таны дээд сонирхол Карьер группүүдийн жагсаалтад өндөр биш байна. Жишээ нь, та математикт дуртай байж болох ч санхүү тооцоолол талдаа сонирхолгүй байж болно. Тиймээс карьерын бүлэг, Computational/Санхүүгийн талаарх таны оноо өндөр биш байна гэсэн үг.

Дараах мэдээлэл танд тохирох ажил мэргэжлийн бүлгийн онооны бүтцийн талаар дэлгэрэнгүйг харуулах болно. Сонирхлын бүлэг тус бүрийн хувьд үйл ажиллагаа, ажил мэргэжил, судлах сэдвүүд гэсэн бүрэлдэхүүн нь таны оноог харуулсан байгаа.


Жич: Бүх бүлэгт "үйл ажиллагаа" хэсэг байгаа ч бүгдэд нь ажил мэргэжил, судлах сэдвүүд гэсэн хэсэг ороогүй.



Энэхүү карьерын бүлэг нь гадаад улс оронд аялах буюу ажиллах, олон орны хүмүүсийг ойлгох, харилцах, нэгээс илүү хэлээр хүмүүстэй харилцах чин хүсэлтэй байхыг хэлнэ. Энэ талбарт өөр өөр улс орны хүмүүстэй хамтран ажиллах, нийтлэг орчин нөхцлийг бүрдүүлэх, бусдад гадаад хэл заах зэрэг үйл ажиллагаанууд багтана. Энэхүү карьерын бүлэгтэй холбоотой ерөнхий ажил мэргэжилд дараах зүйлс багтана.

- ✓ Гадаад үйлчилгээний агент
- ✓ Гадаад хэлний багш
- ✓ Орчуулагч
- ✓ Онгоцны үйлчлэгч
- ✓ Дипломатч/Элчин сайд
- ✓ Аяллын хөтөч/Аялал жуулчлалын агент
- ✓ Олон Улсын Бизнесийн Гүйцэтгэх Захирал
- ✓ НҮБ-ын албан хаагч
- ✓ Хилийн чанад дахь сэтгүүлч/гадаад сурвалжлагч


Энэ салбарын боловсролд соёл хоорондын судлал, антропологи, социологи, сэтгэл судлал, эдийн засаг, улс төрийн шинжлэх ухаан болон хэл зэрэг байж болно.



Энэхүү карьерын бүлэг нь уран бүтээл туурвих замаар санаа бодлоо илэрхийлэхийг хэлнэ. Энэ талбарт зураг зурах, графикаар объектыг урлаж зурах, интерьерийн орчинг зохион бүтээх төлөвлөх, уран баримал хийх, театрын орчныг зохион бүтээх, харааны эффект зохион бүтээх зэрэг үйл ажиллагаанууд багтана. Энэхүү карьерын бүлэгтэй холбоотой ерөнхий ажил мэргэжилд дараах зүйлс багтана.

- ✓ График дизайнер
- ✓ Цахим контент зохион бүтээгч
- ✓ Ногоон байгууламжийн архитектор
- ✓ Загвар зохион бүтээгч
- ✓ Интерьер дизайнер
- ✓ Уран бүтээлч
- ✓ Уран барималч/Үнэт эдлэл урлаач
- ✓ Театр тайзны зураач, зохион бүтээгч
- ✓ Гэрэл зурагчин


Энэ салбарын боловсролд урлаг, зураг, урлагийн түүх, компьютерийн график урлал, интерьер дизайн, баримал эсвэл гэрэл зургийн хичээлүүд орж болно.



Энэхүү карьерын бүлэг нь хууль тогтоомжийг судалж ойлгох, хууль тогтоомжоор дамжуулан бусдын санаа бодол, үзэл бодолд нөлөөлж, хууль дээдлэхийг эрх зүйн системээр дамжуулан дэмжих чин эрмэлзлийг хэлнэ. Энэ талбарт улс төрийн кампанит ажилд оролцох, улс төрийн асуудлаар олон нийтэд үг хэлэх, бичих, шүүхэд үйлчлүүлэгчдийг төлөөлөх, эрх зүйн баримт бичиг зохиох, хууль тогтоомж гаргах, улс төрийн албан тушаал эрхлэх зэрэг үйл ажиллагаа хамаарна. Энэхүү карьерын бүлэгтэй холбоотой ерөнхий ажил мэргэжилд дараах зүйлс багтана.

- ✓ Прокурор
- ✓ Хууль зүйн шинжээч
- ✓ Улс төрийн судалгааны шинжээч
- ✓ Арбитрч/зуучлагч/ Эвлэрүүлэн зуучлагч
- ✓ Хууль тогтоогч (Холбооны, муж, бүс нутгийн)
- ✓ Шүүгч
- ✓ Улс төрийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- ✓ Хууль зүйн туслах, Хуулийн туслах, Хууль зохиогч
- ✓ Сенатор/Конгрессын гишүүн

Энэ салбарын боловсрол нь хууль болон улс төрийн салбарт дээд боловсрол эзэмшихийг шаарддаг.




Ажил мэргэжлийн энэхүү бүлэг нь сүм болон үйлчлэлийн талбарт хувь хүмүүст сүнслэг болон шашны удирдамж чиглүүлэг өгөхийг хэлнэ. Энэ салбарт сүнслэг үйл ажиллагаанд оролцоход нь хүмүүсийг урамшуулан дэмжих, сүнслэг үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хувь хүний сүнслэг болон шашны асуудлаар ярих зэрэг үйл ажиллагаанууд ордог. Энэ салбарт өндөр сонирхолтой олон хүн бүтэн цагаар биш ихэвчлэн сайн дураараа оролцдог. Энэхүү карьерын бүлэгтэй холбоотой ерөнхий ажил мэргэжилд дараах зүйлс багтана.

- ✓ Шашны боловсролын багш
- ✓ Сүмийн магтаал хүндлэлийн удирдагч
- ✓ Сүмийн хүүхдийн үйлчлэгч
- ✓ Сүмийн залуучуудын пастор ахлагч
- ✓ Гадаад эсвэл Дотоодын илгээлтийн эзэн
- ✓ Сайн Мэдээ тараагч
- ✓ Сүмийн ажилтан (Номлогч, Пастор, Багш)
- ✓ Сүмийн үйлчлэлийн удирдагч (Цэргийн, Байгууллагын, Шорон, Эмнэлэг)
- ✓ Шашны сурах бичгийн орчуулагч/Тайлбарлагч/Сэтгүүлч

Энэ салбарын боловсролд шашин судлал, Бурхан судлал, гүн ухаан, илгээлт болон зөвлөгөө өгөх тухай сургалт судалгаанууд орж болно.






Энэ ажил мэргэжлийн бүлэг нь хүмүүстэй ажиллаж, бусдад шинэ ур чадварт суралцаж шинэ санаануудыг эзэмшихэд нь туслахыг хэлнэ. Энэ талбарт төрөл бүрийн сэдвийн хүрээнд заавар зөвлөгөө өгөх, сургалтын үйл ажиллагааг чиглүүлэх, хичээлийн төлөвлөгөө сургалтын материал боловсруулах бэлтгэх, шалгалт өгөх, эсвэл сургуулийн удирдлага зохион байгуулалтад хяналт тавих зэрэг үйл ажиллагаанууд багтана. Энэхүү карьерын бүлэгтэй холбоотой ерөнхий ажил мэргэжилд дараах зүйлс багтана.

- ✓ Худалдааны зааварлагч
- ✓ Корпорацийн сургагч багш
- ✓ Сургуулийн захирал
- ✓ Дээд боловсролын удирдах ажилтан
- ✓ Профессор
- ✓ Боловсрол хариуцсан мэргэжилтэн
- ✓ Сургалтын туслах ажилтан/анги танхимын тусламж
- ✓ Онлайн сургалтын дизайнер (онлайн эсвэл танхим)
- ✓ Эрдэм шинжилгээний багш, Түтөр (Улсын, хувийн болон гэр сургууль)


Энэ салбарт боловсрол эзэмшихийн тулд ихэвчлэн их, дээд сургуульд элсэн суралцах шаардлагатай байдаг бөгөөд заримд нь бага, дунд, дээд боловсрол эзэмших зэрэг нэмэлт боловсрол хэрэгтэй байдаг.



Энэхүү карьерын бүлэг нь төсөл болон хүмүүсийг удирдах, мөн бизнес эрхлэх зэрэг бизнестэй холбоотой үйл ажиллагаануудыг багтаадаг. Энэ талбарт үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, систем зохиох, бусдад ажил үүрэг хуваарилах, хүмүүстэй харилцах, төсөл хэрэгжүүлэх, офисын тоног төхөөрөмж ажиллуулах болон ашгийн бус байгууллагуудад хандив цуглуулах, хүмүүст санаа тавих зэрэг үйл ажиллагааг хамруулна. Энэхүү карьерын бүлэгтэй холбоотой ерөнхий ажил мэргэжилд дараах зүйлс багтана.

- ✓ Банкны Теллер
- ✓ Худалдаа Борлуулалтын Холбоо
- ✓ Захиргааны албаны туслах ажилтан
- ✓ Туслан гүйцэтгэх ажилтан
- ✓ Тусламжийн ширээний ажилтан
- ✓ Хөтөлбөр буюу Төслийн зохицуулагч
- ✓ Оффис менежер
- ✓ Энэрэлийн байгууллага/Төрийн бус байгууллага, Өмгөөлөгч
- ✓ Хүлээн авагч (Зочидтой мэндлэх, угтан авах, уулзалтын цаг товлох, утасны дуудлагад хариулах)


Энэ салбарын боловсролд бизнесийн удирдлага, зохион байгуулалт, харилцаа холбоо, хүний нөөц зэрэг чиглэлүүд байж болно.



Ажил мэргэжлийн энэ бүлэг нь урлаг уран сайхан, мэдээ мэдээлэл, бичгээр болон үг яриагаар дамжуулан хүмүүст урам зориг өгч харилцахыг хэлнэ. Энэхүү карьерын бүлэгтэй холбоотой ерөнхий ажил мэргэжилд дараах зүйлс багтана.

- ✓ Мэргэжлийн дуучин/бүжигчин/загвар өмсөгч
- ✓ Жүжигчин/ Хошин шогч
- ✓ Зохиогч/Бичээч (ном, блог, веб контент, сошиал медиа)
- ✓ Радио/ТЕЛЕВИЗ /Подкаст хөтлөгч
- ✓ Хөгжимчин/Хөгжмийн удирдаач
- ✓ Камер оператор, Телевиз, Видео, Кино
- ✓ Продюсер/Захирал
- ✓ Дуу болон дүрсний техникчид
- ✓ Сонин хэвлэл, сурвалжлагч, сэтгүүлч

Энэ салбарын боловсролд бичих болон харилцах, хөгжим, бүжиг, уран сайхан, /эсвэл дизайн гэх мэт/ байж болно.



Энэхүү карьерын бүлэг нь математик буюу санхүүгийн томъёо, ойлголт, програм хангамжийг ашиглан нарийн төвөгтэй асуудлуудыг шийдвэрлэхэд төвлөрдөг. Энэ талбар нь үйлчлүүлэгчдэд татварын тайлан бэлтгэх, математик томъёог задлан шинжлэх, төсөв гаргах тооцоолох, эсвэл статистик мэдээллийг ашиглах зэрэг үйл ажиллагаануудыг багтаадаг. Энэхүү карьерын бүлэгтэй холбоотой ерөнхий ажил мэргэжилд дараах зүйлс багтана.


- ✓ Компьютерийн програм хангамж Програмист
- ✓ Дата мэдээллийн шинжээч
- ✓ Нягтлан бодогч/Нярав
- ✓ Эдийн засагч
- ✓ Банкны ажилтан/Зээлийн ажилтан
- ✓ Санхүү/хөрөнгө оруулалтын шинжээч
- ✓ Нягтлан бодогч
- ✓ Статистикч
- ✓ Санхүү төлөвлөгч/Зөвлөх

Энэ салбарын боловсролд нягтлан бодох бүртгэл, санхүү, статистик, математик, компьютерийн шинжлэх ухаан эсвэл эдийн засаг орж болно.


## 2.2 Нийлбэр оноо

Дараах хүснэгт таны хийх дуртай зүйл, сонирхдог ажил мэргэжил, судлах дуртай сэдвүүд хэсэгт авсан бодит стандартчилагдсан оноонуудыг агуулж байгаа. Эдгээр нь сүүлийн хэдэн хуудсан дээр танилцуулсан ерөнхий сонирхлын бүлгийг бүрдүүлж байгаа категориуд юм. Графикаар хамгийн бага сонирхол (зүүн), дундаж сонирхол (дунд хэсгээр), мөн хамгийн их сонирхол (баруун) илэрхийлэгдсэн. Эдгээр нь сонирхлын оноонууд бөгөөд эдгээрийг өөрийн ур чадвар ба туршлагатай холбох **хэрэггүй** гэдгийг санаарай.


## Хийх дуртай зүйлс



## Сонирхдог ажил мэргэжил



## Сонирхож судалдаг сэдэв



## 2.3 Эхэнд багтсан боломжит ажил мэргэжлийн жагсаалт

Meggan, Өмнөх хуудсуудад тайлбарласан таны хамгийн өндөр оноо бүхий ажил мэргэжлийн бүлгүүд нь таны сонирхлыг хамгийн ихээр татдаг ажил мэргэжлийн бүлгүүдийн ерөнхий тодорхойлолтоор таныг хангана. Тус бүлэгт байгаа зарим тодорхойлолтууд болон ажил мэргэжлүүд таны сэтгэлийг нэг их татахгүй байж болох юм. Энэ бол хэвийн зүйл юм. Зүгээр л өөрийн юунд дургүй байгааг тэмдэглэж аваад дуртай ажил мэргэжлийн шалгуураа илүү нарийсгахын тулд үүнийг ашиглаарай. Мэдээж энэ дүгнэлтийн бусад хэсэгт буй мэдээллүүд ба хавсаргасан **Карьер Диарект®-ын анкет** болон **Карьер Диарект®-ын эх сурвалжууд** гэсэн хэсгүүд танд үүнийг хийхэд туслана.

Эдгээр болон бусад бүлгүүдэд багтсан ажил мэргэжлийн дэлгэрэнгүй жагсаалтыг *Карьер Диарект®-ын үнэлгээнд* хавсаргасан *ажлын загварт* харуулсан. *Ажлын загварт* 1,600 гаруй ажил мэргэжлүүдийг таван үндсэн ерөнхий сонирхлын бүлэгт (хийх, туслах, нөлөөлөх, дүгнэн шинжлэх, ба илэрхийлэх)хуваасан. Эдгээр олон янзын ажил мэргэжлийн категориудыг таны дүгнэлтэд харуулсанчлан 21 Ерөнхий Сонирхлын Ажил Мэргэжлийн Бүлгүүд болон маш олон тооны ажил мэргэжлийн бүлгүүд болгон зохион байгуулсан.

### СОНИРХОЛ БАГАТАЙ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЖАГСААЛТАА ХАРНА УУ.

Та өөрийн сонирхол багатай дөрвөн бүлгийг анхаарч мэдэх нь чухал. Тэдгээрийг дараах хүснэгтэд жагсаасан байна. Хамгийн бага оноо авсан талбарууд нь таны ажил мэргэжлийн сонирхлын талаар зарим чухал зүйлийг илчлэн харуулж байдаг.



Бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нарийн төвөгтэй үйл ажиллагааг зохицуулах, тээвэрлэлт, түгээлтийн үйлчилгээ үзүүлэх.



Шинжлэх ухааны судалгаа явуулах, физик буюу химийн үйл явцыг судлах, эсвэл өвчнийг судлах, оношлох.



Эмчилгээ судалгаа явуулах, өвчин эмгэгийг оношлох ба эмчлэх, эрүүл мэндтэй холбоотой эмчилгээ үйлчилгээ үзүүлэх, бүртгэл хөтлөх.



Үр тариа, мал аж ахуйг өсгөн үржүүлэх, байгал орчны тохижилтыг хийх, арчлах, судлах, байгаль орчныг хамгаалах.

Жич: Мэргэжлийн/ерөнхий сонирхлууд нь ур чадвараас ялгаатай. Эдгээр нь таны тухайн ажил мэргэжлийн талбарт хандсан хүсэл эрмэлзлийг харуулах болохоос тухайн ажлын талбарт та ажиллах чадвартай эсэхийг харуулахгүй. Ихэнх хүмүүст сонирхлынх нь дагуу тэднийг дэмжихүйц ур чадвар байдаг. Хэрвээ үгүй бол тэд ихэвчлэн яваандаа ур чадвараа хөгжүүлэх гэж оролддог эсвэл өөр хоёрдогч ажил мэргэжлийн талбарыг эрэлхийлдэг. Жишээлбэл, спортод дуртай ч мэргэжлийн тамирчны амьдралыг хөөж чадахгүй нэгэн нь тамирчдын дасгалжуулагч юм уу, спортын шүүгч болох замыг сонгож болох юм.

### Хэсэг 3: Ур чадвар ба чадамж

# Ажил мэргэжил сонгоход тухайн талбарын ур чадварын гол шалгуур

## Ажил мэргэжил сонгоход тухайн талбарын ур чадварын гол шалгуур


Meggan, Ур чадвараа ойлгоно гэдэг нь та өөрийн чадавхи, ажил мэргэжлээ үнэлж цэгнэхтэй ижил чухал. Ямар нэг зүйл хийснээр аяндаа өөрийн эрхгүй ирдэг тэрхүү баяр хөөрийг мэдрэхийн тулд ажил мэргэжлийн талбараа өөрийн хамгийн шилдэг ур чадвартайгаа нийцүүлэх нь хамгийн чухал.

Өөрийн төрөлх чадвараа хөгжүүлэх нь хоёр чухал шалтгаантай. Нэгдүгээрт, энэ нь танд өөрийн чадавхийг хамгийн дээд хэмжээнд байлгахад тусална. Өөрийн төрөлх чадвараа ашиглан ажиллах нь таныг илүү өндөр түвшнээс эхлэн, илүү хурдан суралцаж, ижил хэмжээний хүчин зүтгэл гаргаж илүү ихийг гүйцэлдүүлж чадахад туслана. Жишээлбэл, зарим хүмүүс хэдэн жилийн турш дуу дуулж давтсан ч дуучны хувьд амжилт гаргах чадваргүй байдаг. Учир нь тэдний хувьд энэ тал дээр төрөлх ур чадвар дутагддаг байна.

Хоёрдугаарт, өөрийн төрөлхийн чадварын дагуу ажиллах нь зүгээр л илүү хөгжилтэй, зугаатай байдаг. Хүмүүс төрөлхийн гаргууд сайн ур чадвараа ашиглаж байх үед тэдэнд ажлаас ирэх дарамт бага байдаг гэдэг нь үнэн. Мөн тэд аль хэдийн ийм чадвартай гэдэг нь бусдад танигдаж, хүлээн зөвшөөрөгдөж, үнэлэгдэж, зохих ёсоор шагнагдсан учраас эдгээр чадвараа ашиглахдаа таатай байх нь мэдээжийн хэрэг юм. Төрөлх чадвараа ашиглах үед таны өөртөө итгэх итгэл байнга өсөх ба энэ нь ирээдүйд таныг илүү их баяр хөөр, амжилт уруу дагуулж чадна.


Эцсийн дүнд та өөрийн төрөлх чадваруудаа ашиглах үедээ амжилттай байх магадлал өндөр бөгөөд тэдгээрийг ашиглах нь баяр хөөрийг танд өгч байдаг. Хэдийгээр та сул талуудаа мэдэж анзаарч байх хэрэгтэй боловч ажиллахдаа тэдгээрт гол анхаарлаа хандуулах нь ихэнхдээ үр бүтээлгүй байдалд хүргэдэг аж. Тэгэхээр та өөрийн чадварын эсрэг биш харин чадвартаа нийцүүлж алхахыг хичээгээрэй.

### Ур чадвар ба чадамж




Жич: Энэ хэсгийн ур чадварын оноо нь таны гүйцэтгэл/амжилтын тестийн үр дүнгээс биш харин өөрийгөө үнэлэх үнэлгээний үр дүн юм. Судалгаанаас үзвэл өөрийгөө үнэлэх үнэлгээ нь хувь хүнд өөрийн ур чадварын талаар үнэн зөв ойлголт өгдөг аж.

### 3.1 Ур чадвар ба чадамж: Өндөр оноо бүхий 4 талбар




Хэрвээ та удирдлага хэсэгт өндөр оноо авсан бол та ихэвчлэн шинэ санаагаар дүүрэн, бусадтай харилцах харилцаанд санаа тавьдаг нэгэн байна. Та магадгүй алсын хараатай, идиалистик бөгөөд бусдад нөлөөлөл үзүүлэхэд үргэлж бэлэн байдаг. Багийн удирдлагаар сонгогдон ажиллах, эсвэл та баг дотроос хамтран ажиллаж байгаа хүмүүстээ туслан удирдах чадвартай. Ямар ч байр сууринаас удирдаж байсан, та өөрийн үнэнч, найдвартай байдлаараа бусдад хүндлэгддэг. Харилцаа байгуулах дээр бусдад заах, бусдыг менторлох боломж олдох нөхцөлүүдийг эрэн хай.



Та гадаад хэлэнд дурладаг шигээ өөр улс орны хэл соёл, хүмүүстэй холбогдохыг хүсдэг. Та өөр соёл, амьдрал ахуйг хурдан ойлгох дасан зохицох чадвартай. Та соёл болон уламжлалыг мэдрэхийн тулд хамгийн түрүүнд аялах дуртай. Тиймээс та бусад орноор аялан хэл соёл сурч, орчуулга хийж, үүнийгээ хүмүүнлэгийн болон бизнес, улс төр, нийгмийн халамж гээд ямар ч салбарт ашиглаж болно.



Та бусдын хийж байгаа үйл ажиллагааг удирдан зохион байгуулахдаа гарамгай байдаг байх. Та ажил үүргийг бусдад даалгаж, хүмүүс хоорондоо хамтран ажиллахыг урамшуулж, ажлаа цаг хугацаанд нь амжилттай дуусгадаг. Учир нь хүмүүс таны удирдамж чиглүүлгийг дуртайяа хүлээн авдаг. Та төслийн менежментийн чадвартай бөгөөд нарийн төвөгтэй ажлыг дуусгахад шаардлагатай ажлын үе шат бүрийг урьдчилан харж, удирдаж чадна. Та гэнэтийн яаралтай асуудлыг зохицуулахын тулд уян хатан чадвараа ашиглаж тухайн мөчид тохируулан ажиллаж чаддаг. Нөхцөл байдлыг хурдан үнэлж гэнэтийн өөрчлөгдөж буй орчинд дасан зохицож чаддаг. Эдгээр ур чадвараа дээд зэргээр ашиглахын тулд та бизнес эхлүүлэх, бусдыг удирдан манлайлах болон аливаа үйл ажиллагааг удирдан зохицуулах зэрэг мэргэжлүүдийг бодож үзэх хэрэгтэй.



Үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд нарийвчилсан журам, материалыг хэрхэн зөв, сайн дарааллаар хадгалах ёстойг та аяндаа ойлгодог. Та ажилдаа арга барилтай, цэвэрч нямбай, системтэй ханддаг бөгөөд оффис эсвэл үйлчлүүлэгчдэд тулгардаг бизнесийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахын тулд мэдээлэл, хангамжийг эмх цэгцтэй эрэмбэлэх, цуглуулах зэрэг захиргааны үүргээ сайн гүйцэтгэдэг. Төлөвлөлт, хуваарь гаргах, ердийн ажлуудыг гүйцэтгэх, дахин давтагдах нарийн ур чадвар, чанарын хяналт зэрэг нь олон ажлыг саадгүй хийж чаддаг. Нарийвчлалтай өгөгдөл/бараа материалын менежмент, үндсэн математик, тодорхой харилцаа, захиргааны дэмжлэг эсвэл харилцагчийн үйлчилгээ, оффисын машин эсвэл тусгай багаж хэрэгслийг ашиглах ур чадвар бүхий карьеруудыг эрэлхийлснээр давуу талаа нэмэгдүүлээрэй.

### 3.2 Ур чадвар ба чадамж: Өөрийн чадварыг дүгнэх

Өөрийн хамгийн өндөр оноо авсан ур чадваруудаа анхааралтай шалгаж, тэдний хоорондын харилцаанд дүн шинжилгээ хийгээрэй. Хэр их зүйл давхацсан байна вэ? Таны чадваруудын хувьд нийтлэг төрөл зүйл байна уу? Таны ур чадваруудын аль нэг нь таны хувьд ажил мэргэжлийн суурь болгохоос илүү хобби, сонирхол болгон хийх зүйлстэй холбогдож байна уу? Хэрвээ тийм бол тэдгээр хоббитой холбоотой чадваруудыг ажилдаа ашиглаж болох уу? Таны дүгнэлттэй хавсаргах "Хэрэгжүүлэлтийн Төлөвлөгөө" нь эдгээр болон бусад асуултуудад хариулахад танд удирдамж болно. Энэ дүн шинжилгээг хийх нь өөрийн үнэлгээний дүгнэлтийг бүрэн дүүрэн ашиглах гол түлхүүр тань болох болно.




## УР ЧАДВАРАА ХӨГЖҮҮЛЭХ

Төрөлх давуу талаа ажилдаа ашиглана гэдэг нь та цаашид ур чадвараа хөгжүүлэхийн тулд ямар ч сургалт, боловсрол эзэмших, шаргуу хөдөлмөрлөх болон өөрийгөө бүрэн зориулах хэрэггүй гэсэн үг биш. Харин ч эсрэгээрээ, хамгийн амжилттай яваа хүмүүс хийж байгаа зүйлээ хичээнгүйлэн хийснээр илүү амжилтад хүрсэн байдаг. Төрөлхийн спортын чадвараа өдөр бүр хэдэн зуун бөмбөг цохисноор хөгжүүлж буй мэргэжлийн гольфын тамирчныг бодоод үз. Үүнтэй адил, төрөлхийн хөгжмийн чадвараа бүрэн хөгжүүлэхийн төлөө өдөр бүр хэдэн цагаар давтлага хийдэг төгөлдөр хуурчийг ч бодоод үзээрэй.

## БАГА ҮНЭЛГЭЭТЭЙ УР ЧАДВАРЫГ БАГА АШИГЛА

Meggan, Сонирхлын хэсэгтэй адил та бас хамгийн бага оноо авсан хэсгээ анхаарч харах хэрэгтэй. Тэдгээр нь өмнөх хуудсанд буй хүснэгтийн хамгийн доогуур жагссан байгаа. Бага оноо авсан хэсгүүд нь таны ажил мэргэжлийн сонирхлын талаар зарим зүйлсийг илэрхийлдэг. Эдгээр нь таны төрөлхийн ур чадвар биш байж болох эсвэл танд эдгээр чадварыг хөгжүүлэх боломж гарч байгаагүй байж болох юм. Аль нь ч байсан таны хувьд эхлээд маш сайн сургалт хийж, бэлтгэгдээгүй л бол эдгээр бага оноо авсан ур чадварыг ихээр ашиглах ажил мэргэжлийг сонгохгүй байх нь дээр.

## ЧАДВАРЫН ХУВЬД БАГА ҮНЭЛГЭЭТЭЙ 4 ТАЛБАР



# Үнэт зүйлс нь ажил мэргэжлийн шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой.

### Үнэт зүйлс нь ажил мэргэжлийн шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой.

Meggan, Та өөрийн мэргэжлийн сонирхол, ур чадвар, хувийн мөн чанартай нийцэхүйц ажлын талбарт байсан ч уг ажил таны амьдралын үнэт зүйлстэй нийцэхгүй л бол та ажилдаа сэтгэл дундуур, дарамттай байдлыг мэдрэх боломжтой. Жишээ нь, олон хүмүүс гадаа хийдэг ажлыг үнэ цэнэтэйд тооцдог бөгөөд тэд байшин дотор хашигдан ажилласнаар хэзээ ч бүрэн сэтгэл хангалуун байж чадахгүй. Зарим хүмүүсийн хувьд магадгүй хийж буй ажлаараа дамжуулан шууд бусдад тусалж байна гэж мэдэх хэрэгтэй байдаг бөгөөд ганцаараа ажиллах, эсвэл машин техниктэй ажиллах нь тэдэнд сэтгэл хангалуун байдал өгдөггүй.

Олон хүмүүс материаллаг талаасаа амжилтанд хүргэж чадах зүйл л хийвэл тэд аз жаргалтай байж чадна гэж боддог. Гэвч ихэнхдээ тэд бүгдээрээ тухайн ажлаа хэдхэн жил хийгээд л өөрсдийгөө сэтгэл хангалуун бус, тамирдаж ядарсан байдалтай байгааг мэддэг. Ажил мэргэжлийн сонголт хийхдээ өөрийн үнэт зүйлсийг чухал шалгууруудын нэг болгох нь өнөөгийн ажлын байруудад түгээмэл тохиолддог дарамт, урам хугаралыг хамаагүй багасгаж чадна. Та өөрийн чухалчлах зүйлсээ дүгнэхдээ өөрийн тууштай байгаа эсэхийг нэг анзаараарай. Тэдгээрийг өөрийн яг одоо хийж буй зүйлстэйгээ харьцуулж үзээрэй. Энэ үнэт зүйлс дэх гурван ангилал нь ажил амьдралд чинь удирдамж болох үнэт зүйл болон чухалчлах зүйлсийн дэс дарааллыг тодорхойлоход туслахын тулд хийгдсэн.


Таны үнэт зүйлс өөрчлөгдөх боломжтой; эдгээр нь таны хувьд юу хамгийн чухал болохыг харуулж байгаа бөгөөд та тэднийг хүссэн үедээ өөрчилж болно. Ихэнх хүмүүсийн хувьд нас ахихын хэрээр, мөн гэр бүлийн нөхцөл байдлаас хамааран амьдралд чухалчлах зүйлс нь өөрчлөгддөг. Энэ дүгнэлтийг ирээдүйд дахин эргэж харах баримт болгон хадгалах нь зүйтэй. Үе үе эргэн харж дүгнэж байх нь танд мэдээллээ шинэчилж, амьдралын чухал зүйлсээ хэр баримталж байгааг шалгахад тустай.

## 4.1 Үнэт зүйлс : Ажлын орчин

Хүн хамгийн өндөр үр бүтээмжтэй ажиллахын тулд ажлын өөр өөр орчин нөхцийг илүүд үздэг. Ажлын орчин нөхцөл, цагийн хуваарь, ажлын байрны уур амьсгал зэрэг нь тэдний ажлын үр дүнд нөлөөлдөг. Жишээ нь, зарим хүн маш сайн зохион байгуулалттай орчинд ажиллах хүсэлтэй байхад, зарим нь эмх цэгцгүй замбараагүй орчинд санаа зовохгүй ажиллаж чаддаг.

Хамгийн өндөр үр бүтээмжээр ажиллахын тулд та ямар орчин хүсэж байгаагаа, хэрэгтэй байгаагаа тодорхойлох чадвартай байх нь чухал юм. Үүнийг мэддэг байх нь амьдралд чинь гарч ирэх ажил мэргэжлийн янз бүрийн боломжуудыг зөв тодорхойлоход тань тусална.

### АЖЛЫН ОРЧИН НӨХЦӨЛТЭЙ ХОЛБООТОЙ 12 ЧУХАЛ ЗҮЙЛИЙГ ЭРЭМБЭЛЭХ НЬ



### БОЛОМЖИТ АЖИЛ МЭРГЭЖИЛ, АЖЛЫН БАЙРНЫ ТАЛААР ДҮГНЭЛТ ХИЙХДЭЭ ХАМГИЙН ӨНДӨР ОНООТОЙ 4-ИЙГ НЬ ЧУХАЛ ШАЛГУУР ГЭЖ ҮЗЭЭРЭЙ.

#### 1. Бие даасан байдал

Та өөрөө шийдвэр гаргахыг хүсдэг тул харьцангуй бие даасан хараат бус ажлыг хайх хэрэгтэй. Аливааг өөрийн хийхийг хүсч буй аргаар хийх боломжтой байх нь танд чухал. Хүн бүрт удирдамж заавар хэрэгтэй хэдий ч таны хувьд өөрийн санаануудыг турших боломжтой, хэн нэгнээр ажлаа байнга хянуулаад байхааргүй ажил хийх нь чухал.

#### 2. Адал явдал/ эрсдэл

Хэдий ямар нэг байдлаар эрсдэлтэй байсан ч та үйл явдал өрнөж буй цэгт байхыг хүсдэг. Адал явдалд оролцож, мэдэгдэхгүй, төсөөлөөгүй зүйлстэй тулах нь таныг ажилдаа илүү идэвхитэй, урам зоригтой байхад тусална.

#### 3. Аялал

Та дэлхийн өөр өөр газар уруу аялж өөр өөр зүйлсийг харах боломжтой ажлуудыг эрэлхийлээрэй. Та шинэ хүмүүстэй уулзах, ойр ойрхон аялах, оффисоос хол хийх ажил үүргүүдэд дуртай.

#### 4. Шалгуур сорил


Хэцүү асуудлуудыг шийдвэрлэх, амжилт олох уу-бүтэлгүйтэх үү эсэхийг шийдвэрлэх эгзэгтэй асуудлуудтай ажиллах боломж танд хэрэгтэй. Хэцүү даалгаврууд болон давж гарах шаардлагатай саад тотгоруудыг эрж хай. Зөрчилдөөн бол асуудал биш, яагаад гэвэл та эмх замбараагүй болсон газарт сэргээн босгох ажил хийх дуртай.

## 4.2 Үнэт зүйлс : Ажлын үр дүн

Хэдийгээр ихэнх хүмүүс өөрсдийн хийж буй ажлаас хэд хэдэн янзын шагнал урамшуулал хүлээж байдаг ч хамгийн чухал нь аль нь болохыг шийдэх нь чухал. Жишээлбэл, ер нь өндөр боловсрол өндөр цалин хоёр хамт явдаг хэдий ч тодорхой хэмжээний өндөр боловсрол эзэмшлээ гээд энэ нь өндөр цалин авахад нөлөөлөхгүй байж болно. Үүнчлэн удирдах албан тушаалд байна гэдэг нь тухайн хүний аюулгүй байдлыг баталгаажуулдаггүй. Бид үүний талаар бодож үзсэн ч, үгүй ч энэ тал дээр бид чухал шийдвэр гаргах хэрэгтэй болдог.

Таны чухалчлах зүйлс бол зөвхөн таны хувийн асуудал гэдгийг ойлгох нь маш чухал. Ажил мэргэжил сонгохдоо хүмүүсийн гаргадаг хамгийн том алдаануудын нэг бол ажлын хувьд эрхэмлэх зүйлстээ өөр хэн нэгний нөлөө, саналыг хэт их оруулах явдал юм. Энэхүү чухал зүйлийн талаар маш сайн бодож үзээд таны хувьд хамгийн чухал зүйлс юу болохыг тодорхойлж ухаарна гэдэг нь онцгой боломж юм.

### АЖЛААСАА ХҮЛЭЭДЭГ ЧУХАЛ 8 ҮР ДҮНГ ЭРЭМБЭЛЭХ НЬ



### ТАНЫ ХУВЬД ЭДГЭЭР ҮР ДҮН ХАМГИЙН ЧУХАЛ

#### 1. Хүлээн зөвшөөрөл

Та өөрийн хийх ёстойгоо хийсэн гэж бусдад танигдахын төлөө шаргуу хөдөлмөрлөхөд бэлэн байдаг. Гүйцэтгэлийг чинь хүлээн зөвшөөрч сайшаах нь таны хувьд ажлын томоохон өдөөгч болдог бөгөөд ажилд орохоор боломжуудыг судлах үедээ шагнал урамшууллын систем нь тодорхой бөгөөд сайн газрыг сонгоорой.

#### 2. Удирдах байр суурь

Хүмүүсийг болон нөөцүүдийг хариуцдаг ажил хийх нь танд таатай байдаг. Та аливааг хариуцаж, бусдад юу хийхийг нь хэлэх, багийнхаа төлөө шийдвэр гаргах дуртай. Таны хийх ажилд нийтлэг зорилгын төлөө багийг удирдах боломжууд багтсан байх ёстой.

#### 3. Бусдад туслах

Бусдын сайн сайхан, өсөлтийн төлөө хувь нэмэр оруулах нь таны хувьд их чухал бөгөөд энэ зүйл таны ажлын салшгүй нэг хэсэг нь байх хэрэгтэй. Энэ нь сургалт, заах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, урамшуулах болон санхүүгийн эх үүсвэрээр хангах зэргээр дамжуулан хийгдэж болох юм. Таны ажлын сонголт чинь бусдын төлөө гэсэн таны сэтгэлийг илэрхийлэх боломж олгохуйц байх ёстой.

#### 4. Оюуны өдөөлт


Та ээдрээтэй асуудлыг бодож тунгаан, асуудлыг шийдвэрлэхийн тулд эргэцүүлэх ур чадвараа ашиглах дуртай. Шинэ мэдээлэл олж авах боломжтой бөгөөд сэтгэн бодох чадвар шаардсан байдлыг та ажил сонгох шалгуурынхаа нэг хэсэг болгох ёстой.

### 4.3 Үнэт зүйлс : Амьдралын үнэт зүйлс

Олон хүмүүс амьдарч, ажиллаж байгаа байдлаа өөрийн амьдралын үнэт зүйлстэй тааруулж чаддаггүй асуудалтай байдаг учраас энэ хэсэг ажил мэргэжил төлөвлөлтөд маш чуал. Өнөө цагийн амьдралын хурдан хэмнэл, хэрээс хэтэрсэн санхүүгийн хэтэрсэн дарамт, амьдралын адармаатай асуудлууд олон хүнийг зөвхөн өнөөдрөө л аргацааж амьдарах нь тэдний хийж чадах ганц зүйл гэж санахад хүргэдэг.

Хэдий тийм боловч туршлагаас харвал, амьдралын зорилгын талаар нухацтай бодож шийдвэр гарган, тэрхүү зорилгынхоо төлөө ажлаа сонгох нь ажилдаа сэтгэл хангалуун бөгөөд энэ тал дээр ер бусын амар тайван байлгаж чаддаг. Дараагийн хуудсанд амьдралын зорилготой холбоотой таны хамгийн чухалд тооцдог дөрвөн зүйлийг жагсаасан.

#### АМЬДРАЛЫН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН 9 ҮНЭТ ЗҮЙЛИЙН ЭРЭМБЭ ДАРААЛЛАЛ



#### ТАНЫ АМЬДРАЛЫН ХАМГИЙН ЧУХАЛ 4 ҮНЭТ ЗҮЙЛ

##### 1. Ололт амжилт

Та өндөр зорилгууд өмнөө тавьж хийж буй бүхнээ гаргууд сайн хийхийн төлөө хичээдэг. Ажлын талбараа өөрийн хүрч чадах хамгийн дээд гүйцэтгэлийг гаргах нь таны хувьд маш чухал. Өндөр зорилго тавиад, гаргасан хичээл зүтгэлийнхээ үр дүнг харах боломжтой ажлын боломжуудыг эрэлхийлээрэй.

##### 2. Итгэл үнэмшил

Хийж байгаа бүхий зүйлдээ Бурханд үйлчлэх нь таны амьдралын эрхэм зорилго гэдгийг та харуулсан. Таны хийж байгаа ажил тэрхүү зорилгод хувь нэмэр оруулж байгааг харах нь танд маш чухал байх болно. Бүхий л ажлын байрууд нь Бурханд үйлчлэх боломж олгодог гэдгийг санах хэрэгтэй. Аливааг онцсайн хийх шийдвэр мөн найрсаг харилцаа тань ажлын орчиндоо бусдыг татах нэгэн гэрэл болж чадна.

##### 3. Гэр бүл

Таны хувьд гэр бүл тань маш их үнэ цэнэтэй бөгөөд та тэдэнд халамж анхаарал шаардлагатай болох бүрд туслахад бэлэн байхыг хүсдэг. Та тэдний хийж байгаа зүйлст оролцох боломжтой байх нь чухал гэж үздэг. Гэр бүлийнхэнтэйгээ чанартай цагийг ихээр гаргах нь таны хувьд нэн чухал бөгөөд үүнийг та ажил мэргэжлийн сонголт хийхдээ анхаарч үзэх ёстой.

##### 4. Гоо зүйн мэдрэмж

Урлагийн чиглэлийн илэрхийлэлүүд болон бүтээлч байдал таны амьдралд дээгүүр байр суурь эзэлдэг. Өөрийн сэтгэл мэдрэмжийг ашиглан, бүтээлч үзэл бодол, ур чадвараа чөлөөтэй илэрхийлэх боломжтой, амьдралыг илүү өнгө үзэмжтэй болгох үйл ажиллагаануудад оролцох та дуртай.

### ҮНЭТ ЗҮЙЛС ДОТРОО ЗӨВ ТЭНЦВЭРИЙГ ОЛООРОЙ

Хэн ч төгс биш, Супермэн Вондэрвүмэн нар бодитоор оршдоггүй. Та хэзээ ч бүх зүйлийг өөрийн хүссэн хэмжээнд хүргэн хийж чадахгүй. Хүн бүр амьдралд тэнцвэртэй хандах ёстой. Өөрийн чухалчлах зүйлсийг бодолцож үзсэнээр та цаг, эрч хүч, санхүүгийн нөөц баялгаа тэнцвэртэй ашиглаж чадна. Чухалчлах зүйлсийн дараалал бүхий жагсаалтаа эргэн харах нь амьдралын зорилготой холбоотой үнэт зүйлсээ сахиж амьдрахад туслах болно.

### ТАНЫ ҮНЭТ ЗҮЙЛС ӨӨРЧЛӨГДДӨГ ГЭДГИЙГ САНА

Эдгээр нь таны чухал гэж үзсэн зүйлс бөгөөд та хүссэн үедээ тэдгээрийг өөрчилж болно. Ихэнх хүмүүсийн хувьд нас ахих, амьдралын нөхцөл байдал өөрчлөгдөхөд чухал зүйлсийн дэс дараалал өөрчлөгдөж байгааг анзаардаг. Энэ дүгнэлтийг ирээдүйд дахин эргэж харах баримт болгон хадгалах нь зүйтэй. Үе үе эргэн харж дүгнэж байх нь танд мэдээллээ шинэчилж, амьдралын чухал зүйлсээ хэр баримталж байгааг шалгахад тустай.

### БИ ОДОО ЮУ ХИЙДЭГ ВЭ?

Ажил мэргэжлийн хөгжил-дэвшлийн үе шатуудаа гэр бүлийн амралтаараа машинаар улс орон дамжин аялахтай харьцуулаарай. Энэ нь хоёр үе шаттай. Нэгдүгээр шатанд нь аялалаа сайхан болгохын төлөө бүхий л шаардлагатай судалгаа, төлөвлөгөөг гаргана. Хоёрдугаар шатанд машиндаа суугаад, хуучин замаасаа гарч, шинээр аялалаа эхлүүлэх үйлдэл багтана.


КАРЬЕР ДИАРЕКТЫН дүгнэлтийг уншина гэдэг нь аялалын эхний үе шатанд газрын зургаа судлаж буйтай адил юм. Энэ нь таны очих газрын замын ерөнхий байдал, чиглэлийг, мөн өөр ямар ямар замаар явах боломж байгааг харуулдаг. Хэдий тийм ч ганц газрын зураг уншаад л зорьж буй газраа хүрдэггүйтэй адил зөвхөн дүгнэлтийг уншаад та ажил мэргэжлийн талаар эргэлзэж буй асуудлуудаа шийдвэрлэнэ гэдэг хангалтгүй юм.

Одоо харин та хоёр дахь үе шатанд ирчихээд байна. Одоо та жолоочийн суудалд суугаад, ажил мэргэжлийн аялалаа эхлэх цаг нь болсон гэсэн үг. Таны анхны алхам бол олж авсан мэдээллээ аялалын талаар шийдвэр, төлөвлөгөөндөө шингээх явдал юм. Энэхүү гол алхмыг хийхэд танд туслахын тулд бид таныг ажилтай холбоотой өөрийн ерөнхий үзэл баримтлалын талаар сурсан зүйлсээ тайлбарлан ойлгоход, ажил хэрэг болгох удирдамж болгон Үйлдлийн Төлөвлөгөөг оруулсан. Та энэ зүйлийг бүрэн гүйцэт хийж дуусгах нь маш чухал. Таныг ажлын талаарх өөрийн үзэл баримтлалаа янз бүрийн ажил мэргэжил болон, боловсролын хөтөлбөрүүдтэй холбон тохируулахад энэ нь танд туслаж чадна.


Дээрхээс гадна, ажил мэргэжлийн төлөвлөгөөний гол зорилго нь өөрийн бэлэг авьяас, хүсэл сонирхлоо тухайн ажлын тавигдах шаардлагад нийцүүлэх явдал гэдгийг битгий мартаарай. Ингэснээр та өөрт тохирсон бариа буюу ажил мэргэжилд хүрэх хамгийн өндөр магадлалтай юм.

# Хувийн мөн чанарын хураангуй

## 1.1 Хувийн мөн чанарын зургаан хүчин зүйл



## 1.2 ТАНЫ МӨН ЧАНАРЫН ХҮЧИН ЗҮЙЛС, ДЭД ХҮЧИН ЗҮЙЛС



### 1.3 ХУВИЙН МӨН ЧАНАРЫН ХУРААНГУЙ

**Адал явдалд дуртай** - Эрсдэлтэй алхам хийдэг, зорилгынхоо төлөө тууштай зүтгэдэг, өрсөлдөх дуртай бөгөөд өөрийн чадварыг сорьсон ажилд татагддаг.

**Энэрэнгүй** - Өрөвч энэрэнгүй, мэдрэмтгий, бөгөөд сайн сонсогч; тэвчээртэй, үнэнч, бусдыг дэмжих, зоригжуулахдаа сайн.


**Шинийг санаачлагч** - Маш бүтээлч. Та онцгойлон шинэ санаануудыг боловсруулж, илэрхийлэх дуртай бөгөөд оюуны хүч сорьсон зүйлсийг эрэлхийлдэг.

**Гадагшаа** - Гадагш чиглэсэн, шинэ хүмүүстэй уулзах дуртай төрөлхийн хүмүүс төвтэй нэгэн; та хүсэл тэмүүлэл дүүрэн бөгөөд бусадтай харилцаа холбоо тогтоохдоо сайн.


**Удирдангүй** - Зоримог, өөртөө итгэлтэй, үр дүнг чухалчилдаг бөгөөд төрөлхийн удирдах хүсэл эрмэлзэлтэй.

**Баригдмал биш / Нягт нямбай (Дундаж -түвшин)** - Зарим зүйл дээр зохион байгуулалттай ч зарим зүйлсэд урсгалаараа тохируулж үйлддэг.

### 1.4 Амьдралын чухал асуудлууд




### 2.1 Ерөнхий сонирхол







## 2.2 Хамгийн их сонирхож буй 8 ажил мэргэжил




## 3.1 Ур чадвар ба чадамж



## Эхний 4-т эрэмбэлсэн үнэт зүйлс



## Амьдралын чухал үнэт зүйлс



## Карьер Диарект – Дараагийн алхмууд

Карьер Диаректын үнэлгээг хийж дуусган дэлгэрэнгүй дүгнэлттэйгээ танилцсанд баяр хүргэе!

Таны ойлгох хэрэгтэй цөөн хэдэн үндсэн зарчим бий. Дараагийн алхам руу орохын өмнө хэсэг тус бүрийг анхааралтай судлан өөрийн итгэдэг хэн нэгэн хүнтэй эдгээрийн талаар ярилцаарай.

- Та үл тоомсорлож болохооргүй онцгой давтагдашгүй бүтээгдсэн билээ. Өөрийн онцгой дүр төрхийг таньж мэднэ гэдэг нь өөрийн амьдралд өгөгдсөн тэрхүү ажил үүргийг нээж олоход нэн чухал хэсэг мөн. Өөрийн онцлог байдлыг үл тоомсорлох нь хүнд цөхрөл, буруу шийдвэр, бүр мөсөн тасарсан харилцаа зэрэг үр дагаварт хүргэж болзошгүй.
- Таны насан туршийн ажил гэдэг нь зүгээр л нэгээс нөгөөд шилжих үйл явдлуудын багц төдий биш харин тасралтгүй харилцааны аялал юм. Мэдрэмжтэй хийгээд судлаж шинжлэх, шийдвэр гаргах явцдаа бусдын зөвлөгөө, удирдамжийг авахад нээлттэй бай.
- Өөрийн бүтээгдсэн дүр төрхийг ажил мэргэжилтэйгээ нийцүүлэн хослуулна гэдэг нь таны насан туршийн үүрэг хариуцлага мөн. Таны амьдрал өөрчлөгдөхийн хэрээр танд харилцаа, ажил, амьдралын хувьд хөндийрсөн, холдсон мэт санагдах үеүүд тохиолддог. Энэ нь ихэнхдээ дахин үнэлэлт дүгнэлт хийж, Карьер Диаректын үйл явцыг дахин нэг хийж үзэх хэрэгтэйг илтгэдэг.
- Аялалдаа амжилттай байхад шаргуу хөдөлмөр, итгэмжит байдал, тууштай чанар хэрэгтэй. Өөрийн дүгнэлтийг судлан үзэж, боломжит ажил мэргэжлүүдэд судалгаа шинжилгээ хийх нь зайлшгүй алхмууд бөгөөд өөрийн онцлогт тохирсон ажил мэргэжлийн талбаруудад сайн дураар ажиллаж үзэх нь тустай байж болох юм.
- Та маш чухал ажил мэргэжлийн шийдвэр гаргах гэж байна. Гамшгаас сэргийлэхийн тулд бат бэх суурь байх ёстой. Ажил мэргэжлийн ухаалаг шийдвэр гаргах цорын ганц бат суурь бол:
  - Таны шийдвэр таны бүтээгдсэн дүр төрхтэй нийцэж байгаа эсэхийг нягтлах.
  - Бүтээгчээ хүндэтгэсэн шийдвэр гаргах нь
    - ҮНЭ ЦЭНЭЭ ҮРГЭЛЖ САНАЖ буруу зүйлд үндэслэн шийдвэр гаргахаас зайлсхий!
      - Хамгийн амархан эсвэл хамгийн түрүүнд санал болгосон ажлыг сонгох
      - Мөнгө гол өдөөгч байх
      - Албан тушаал ба нэр хүнд
      - Аюулгүй байдал, эрх мэдэл ба хяналт
      - Найзуудаа дагах
      - "Боломж өндөртэй ажил" хайх
      - Эцэг эхийнхээ замыг дагаж, тэдний мөрөөдлийг биелүүлэх
      - Зүгээр л хийж чаддаг гэсэн шалтгаанаар ажлаа сонгох

**Ажил мэргэжлийн ухаалаг шийдвэр гаргах суурь зарчмуудын талаар та одоо баттай ойлголттой боллоо. Дараагийн алхмаа эхэлцгээе:**

АЛХАМ 1:

- Танд Карьер Диаректын зөвлөх байхгүй бол таны үнэлгээг хамт уншиж танилцан, таны ирээдүйн төлөө байнга залбирах дасгалжуулагч юмуу халамжлагчийн тусламжийг хайж олоорой. Хэрэв та хүсвэл, [Карьер Диаректын зөвлөхтэй яг одоо холбогдоорой!](#)

АЛХАМ 2:

- Карьер Диарект® дахь *дэлгэрэнгүй дүгнэлтийн хариуг* ДАХИН үзэх.
- Дүгнэлтэнд байгаа таньд тохирохгүй мэдээлэлүүдийг анхаараарай. Хэрвээ танд санал нийлэхгүй зүйл байвал өөрийн зөвлөх юм уу дасгалжуулагчаасаа лавлан асууж өөрийн бодлыг нягтлаарай. Хэрэв үнэхээр таны зөв байвал тэдгээр тохирохгүй хэсгүүдийг тэмдэглээрэй.
- Дүгнэлтээс таны болон таны зөвлөхийн анхаарлыг татсан гол зүйлсийг тодруулан тэмдэглээрэй.
- Зөвлөхийн зүгээс танд хэлсэн ажил мэргэжлийн саналуудыг тэмдэглэж аваарай. Хэрвээ та Карьер Диаректын зөвлөх үйлчилгээг аваагүй бол танд ийм санал зөвлөмжүүд өгөгдөхгүй.

АЛХАМ 3:

- Доор өгөгдсөн, таны өндөр оноотой 8 сонирхлын бүлэгт санал болгогдсон буюу таны хүсч буй ажил мэргэжлийн холбоосууд дээр дарж, өөрийн мөн чанар, сонирхол, ур чадвар, үнэт зүйлстэй нийцэх боломжит ажил мэргэжлүүдийг олохын тулд үргэлжлүүлэн судлаарай.
- Ажил мэргэжил бүр онцлогтой, тавигдах шаардлага нь ч өөр. Тиймээс тухайн ажилд тохирох хүний мөн чанар, чадвар, сонирхол, үнэт зүйлс нь тэр шаардлагад нийцэх нь чухал. Таны онцлогийг тодорхойлж буй ДӨРВӨН чухал хэмжигдэхүүн нь

сонгох ажил мэргэжилтэй чинь нягт уялдаж байх ёстойг санаарай. Хувийн мөн чанар, сонирхол, ур чадвар, үнэт зүйлсийн талаар шаардлагатай мэдээлэлийг доорхи ажлын дэлгэрэнгүй мэдээлэл холбоос дээр дарж авна уу.

- Ажлын загварууд (ЭНДЭЭС татаж авах) [хэсгээс өөрийн сонирхож буй тодорхой талбарын ажил мэргэжлийн дэлгэрэнгүй жагсаалтыг аваарай.](#)

## Өндөр оноотой сонирхлын найман бүлэг Ажлын талаарх мэдээллийн холбоос

### 1. Соёл дамжсан харилцаа

Гадаад үйлчилгээний агент Онгоцны үйлчлэгч Олон Улсын Бизнесийн Гүйцэтгэх Захирал	Гадаад хэлний багш Дипломатч/Элчин сайд НҮБ-ын албан хаагч	Орчуулагч Аяллын хөтөч/Аялал жуулчлалын агент Хилийн чанад дахь сэтгүүлч/гадаад сурвалжлагч
---	--	---

### 2. Урлаг/дизайн

График дизайнер Загвар зохион бүтээгч Уран барималч/Үнэт эдлэл урлаач	Цахим контент зохион бүтээгч Интерьер дизайнер Театр тайзны зураач, зохион бүтээгч	Ногоон байгууламжийн архитектор Уран бүтээлч Гэрэл зурагчин
---	--	---

### 3. Хууль/Улс төр

Прокурор Арбитрч/зуучлагч/ Эвлэрүүлэн зуучлагч  Улс төрийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Хууль зүйн шинжээч Хууль тогтоогч (Холбооны, муж, бүс нутгийн)  Хууль зүйн туслах, Хуулийн туслах, Хууль зохиогч	Улс төрийн судалгааны шинжээч Шүүгч Сенатор/Конгрессын гишүүн
---	---	---

### 4. Итгэл үнэмшил/Үйлчлэл ба омлол сургаал

Шашны боловсролын багш Сүмийн залуучуудын пастор ахлагч Сүмийн ажилтан (Номлогч, Пастор, Багш)	Сүмийн магтаал хүндлэлийн удирдагч Гадаад эсвэл Дотоодын илгээлтийн эзэн Сүмийн үйлчлэлийн удирдагч (Цэргийн, Байгууллагын, Шорон, Эмнэлэг)	Сүмийн хүүхдийн үйлчлэгч Сайн Мэдээ тараагч Шашны сурах бичгийн орчуулагч/Тайлбарлагч/Сэтгүүлч
--	---	--

### 5. Боловсрол

Худалдааны зааварлагч Дээд боловсролын удирдах ажилтан Сургалтын туслах ажилтан/анги танхимын тусламж	Корпорацийн сургагч багш Профессор Онлайн сургалтын дизайнер (онлайн эсвэл танхим)	Сургуулийн захирал Боловсрол хариуцсан мэргэжилтэн Эрдэм шинжилгээний багш, Түтөр (Улсын, хувийн болон гэр сургууль)
---	--	--

### 6. Үйлчилгээ/Удирдлага зохион байгуулалт

Банкны Теллер Туслан гүйцэтгэх ажилтан Оффис менежер	Худалдаа Борлуулалтын Холбоо Тусламжийн ширээний ажилтан Энэрэлийн байгууллага/Төрийн бус байгууллага, Өмгөөлөгч	Захиргааны албаны туслах ажилтан Хөтөлбөр буюу Төслийн зохицуулагч Хүлээн авагч (Зочидтой мэндлэх, угтан авах, уулзалтын цаг товлох, утасны дуудлагад хариулах)
--	--	---

### 7. Гүйцэтгэл/харилцаа холбоо

Мэргэжлийн дуучин/бүжигчин/загвар өмсөгч  Жүжигчин/ Хошин шогч Зохиогч/Бичээч (ном, блог, веб контент, социал медиа)	Радио/ТЕЛЕВИЗ /Подкаст хөтлөгч Хөгжимчин/Хөгжмийн удирдаач Камер оператор, Телевиз, Видео, Кино	Продюсер/Захирал Дуу болон дүрсний техникчид Сонин хэвлэл, сурвалжлагч, сэтгүүлч
---	---	--

## 8. Тооцоолол/Санхүү

Компьютерийн програм хангамж  
Програмист

Дата мэдээллийн шинжээч

Нягтлан бодогч/Нярав

Эдийн засагч

Банкны ажилтан/Зээлийн ажилтан

Санхүү/хөрөнгө оруулалтын шинжээч

Нягтлан бодогч

Статистикч

Санхүү төлөвлөгч/Зөвлөх

#### АЛХАМ 4:

- Дэлгэрэнгүй дүгнэлт ба судалгааны гол мэдээлэлүүдийг ашиглан **Үйл ажиллагааны төлөвлөгөө хуудсыг** бөглөөрэй. Энэ алхам нь дараагийн алхмыг гүйцэтгэхийн тулд зайлшгүй хийгдэх шаардлагатай!
- Үйл ажиллагааны төлөвлөгөө хэсгийг хийх үедээ дараах асуултуудыг бодож үзээрэй:
  - Ажлын байранд амжилтад хүрэх боломж танд олгох онцгой давуу талууд болон хүсэл сонирхлууд тань юу вэ?
  - Бурханы танд өгсөн, ажилтай холбоотой ерөнхий шинж чанаруудын хэв маяг нь юу вэ?
  - Таны хамгийн их сонирхдог ажлын талбар, онцгой ажил мэргэжлүүд юу вэ?
  - Таны судалгаанаас харвал эдгээр ажил мэргэжлүүдэд ямар чухал шаардлагууд болон шинж чанарууд тавигдах вэ?
  - Таны онцлог дүр төрхөд ямар талын ажил мэргэжлүүд хамгийн сайн тохирох вэ?
  - Танд хамгийн сайн тохирох тэдгээр ажил мэргэжлийн боломжуудыг эрж олохын тулд та юу хийх вэ?
    - Дагалдан ажил?
    - Сайн дурын үйлчлэл?
    - Дадлагажигч болох?
    - Тухайн ажлыг хийж буй нэгэнтэй ярилцах хэрэгтэй юу?

#### АЛХАМ 5:

- Бурханлаг зөвлөмжийг эрэлхийлэн, таны онцлогт нийцсэн талбаруудад ажиллаж буй хүмүүстэй ярилцаж, мөн эдгээр талбарууд дахь нээлттэй ажлын байрыг судлах энэ бүх үйл явцын туршид залбирсаар байгаарай.

# Эх сурвалж

Энэ хэсэгт ажил мэргэжлийн хувьд үр дүнд хүрэхэд танд тус болох мэдээлэлийн эх сурвалж, үйлчилгээтэй холбогдох цахим холбоосуудыг боломжтой болгосон.

- [Коллежийн мэргэжлүүд ба ажил мэргэжил сонгох удирдамж, цахим ном](#)

*Коллежийн мэргэжлүүд ба ажил мэргэжил сонгох удирдамж* ном нь цаашид суралцаж болох мэргэжлийн хичээлүүдээ олж мэдэхэд бодитой зөвлөгөө өгнө. *Коллежийн/техникийн сургуулийн мэргэжлүүдээс сонгох нь хэмээх* цахим эх сурвалж хэсэгт буй материал нь таныг өөрийн сонирхлыг коллежийн/техникийн сургуулийн мэргэжлүүдтэй нийцүүлэхэд туслах болно.

- [Коллежийн эсвэл техникийн сургуулийн мэргэжлээс сонгох нь](#)

Энэ материал нь хамгийн өндөр оноо авсан ажил мэргэжил болон ажлын талбарууд(хэрэгжүүлэх төлөвлөгөөгөөр гаргасан)аа коллеж болон техникийн сургуулийн мэргэжлүүдтэй хэрхэн холбож, уялдуулах арга замыг багтаасан.

- [Ажлын загвар](#)

*Ажлын загвар* нь таныг хийж болох боломжит ажлуудыг өөрийн ажил мэргэжлийн сонирхол дээр үндэслэн өргөн хүрээнд харж чадахад туслахын тулд хийгдсэн. Таны үнэлгээний тайлан дээр сонирхлын бүлэг тус бүрт есөн ажил мэргэжлийн бичсэн нь зөвхөн жишээ төдий юм. Энэхүү *Ажлын загвар* нь бүхэлдээ ажил мэргэжлүүдийн жагсаалтаас бүрдэх бөгөөд үүнийг доорхи холбоост өгөгдсөн O\*Net ба ажил мэргэжлийн гарын авлага хэсгүүдээс цаашид илүү дэлгэрүүлэн харах боломжтой.

- [O\\*Net онлайн](#)

O\*Net онлайн бол Хөдөлмөрийн Статистикийн албанаас гаргадаг ажил мэргэжлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийн сан юм. Энэ онлайн эх сурвалж нь *ажлын загвар хэсэгт багтсан бүх ажил мэргэжлүүдийн мэдээллийг агуулсан* ба, тухай ажилд шаардлагатай ур чадвар, боловсрол мэдлэг, ажлын үүрэг хариуцлага, өдөр тутмын ажлууд, чадварын түвшин, дундаж цалин гэм мэт олон зүйл багтдаг.

- [Ажил мэргэжлийн онцлогийн гарын авлага](#)

Ажил мэргэжлийн онцлогийн гарын авлагыг ч бас Хөдөлмөрийн статистикийн албанаас гаргадаг бөгөөд америкчуудын эрхэлдэг нийт ажил мэргэжлийн 90 хувийг төлөөлөх хамгийн эрэлт ихтэй 260 топ ажил мэргэжлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлийг агуулдаг.

- [Краун Файнэншл Министриз](#)

Краун Файнэншл Министриз бол *Карьер Диарект® цогц удирдамжийн системийн* үнэлгээг боловсруулсан толгой байгууллага юм. Краун ОУ-ын байгууллага нь урсгал чиглэлээс үл хамааран үйлчлэл явуулдаг бөгөөд чуулганууд, хувь хүн, сургуулиудад санхүүгийн жинхэнэ эрх чөлөөний талаарх хэрэгцээт сургалт семинар явуулж, гарын авлага материалиар хангадаг төдийгүй үндэсний хэмжээний 4 радио хөтөлбөр, шилдэг интернэт цахим хуудас, санхүүгийн зөвлөгөө, ажил мэргэжлийн талаархи эх сурвалжуудаар ч хүрч үйлчилдэг. Энэхүү өргөн цар хүрээтэй үйлчлэлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл манай цахим хуудсаар зочилоорой.

- [Краун Файнэншл Министриз байгууллагын дэлгүүр](#)

Краун Санхүүгийн үйлчлэлээс гаргасан бүх бүтээгдэхүүн, үйлчилгээг харахыг хүсвэл энд дарна уу.

- [Pongo™ товч намтар бичих үйлчилгээ](#)

Маш сайн бичигдсэн товч танилцуулга/намтар нь өнөөгийн их өрсөлдөөнтэй хөдөлмөрийн зах зээл дээр хаалгаар нэвтрэн орж өөрт төгс тохирох ажлын байранд хүрэх цорын ганц чухал хүчин зүйл болоод байна. Товч намтар **БИЧИГЧ** ба **ХЭВЛЭГЧ** нь танд нэг цэгээс- онлайн-аар түргэн хугацаанд, хялбар аргаар товч намтраа бий болгох, хэвлэх, цахим хаягаар илгээх болон факсаар явуулах боломжуудыг хангаж өгнө! (Энэ холбоос нь гуравдагч байгууллагын цахим хуудастай холбоно гэдгийг анхаараарай.)

- [Ажил мэргэжлийн хувийн бүртгэл](#)

Энэ асуулга нь танд дараах алхмуудыг гүйцэтгэхээсээ өмнө ажил мэргэжилтэй холбоотой зарим чухал асуудлуудыг ангиалан ялгахад туслах болно. Та өөрийн мэдээллийг PDF хэлбэрээр бичиж, хэвлэн авч болох боловч энд таны мэдээлэл хадгалагдахгүй.

- [Ажил, мэргэжилээ төлөвлөх хувийн бүртгэл](#)

Өөрийн компьютерийн дэлгэц дээр энэхүү богино асуулгыг бөглөх нь танд ажил мэргэжлийн холбогдолтой чухал асуудлуудыг тодорхойлоход бэлэн байхад тусална.



## Сонсох файлууд:

### Сонсох мэдээлэл #1 - "Ажил мэргэжилдээ сэтгэл ханамжтай байх зарчмууд" (28 минут)

Энэхүү мэдээлэл нь танд ажил амьдралдаа үнэхээр амжилттай байхад туслах мэргэн ухаан, урам зоригийг өгөх болно.

Нэгдүгээр хэсэг: • Бурхан ажлыг бүтээсэн • Бүх ажилд утга учир, үнэ цэнэ бий.

Хоёрдугаар хэсэг:

- Таны дуудлага - Бурханы таны амьдралд зориулсан төлөвлөгөө
- Ажил хөдөлмөр нь үйлчлэл болон гэрчлэлийн индэр юм.

Гуравдугаар хэсэг: • Ажлын байрандаа онц сайн гүйцэтгэлтэй байх • Бурхан бол бидний хамгийн дээд эрх мэдэл

### Сонсох мэдээлэл #2 - "Карьер Диаректыг® хэрхэн хамгийн сайн үр дүнтэй байлгах вэ" (36 минут)

Энэ мэдээлэл нь танд Карьер Диаректын® үнэлгээнээс хэрхэн хамгийн сайн үр дүнг авах талаар нарийн зааврыг өгөх болно.

Нэгдүгээр хэсэг: • Сүүлийн үед ажлын байранд гарч буй өөрчлөлтүүд

Хоёрдугаар хэсэг: • Өнөөгийн ажлын орчин нөхцөл дэх арван чиг хандлага

Гуравдугаар хэсэг: • Холбогдох ажил мэргэжилтэй өөрийн онцлог, хэв маягаа нийцүүлэх

Дөрөвдүгээр хэсэг: • Ажил мэргэжил сонгоход Библийн үзэл баримтлалын ач тус

### Сонсох мэдээлэл #3 - "Бурхан таныг хэрхэн бүтээснийг ойлгох /Карьер Диаректын дүгнэлтээ ойлгох нь" (55 минут)

Энэ мэдээлэл нь хүний Бурханаар бүтээгдсэн давтагдашгүй дүр төрхийн талаарх үндсэн ойлголтыг багтаасан. Бурхан бидэнд өөрсдийн потенциалыг бүрэн ашиглахад шаардлагатай онцгой авьяас, чадваруудыг өгсөн. Карьер Диаректын үнэлгээ нь танд өөрийн онцлог дүр төрхийн талаар ойлголтыг өгөх болно.

Нэгдүгээр хэсэг: • Ажил мэргэжил сонгох зөв ба буруу арга замууд

Хоёрдугаар хэсэг: • Дүгнэлтээ дахин харах - Хувийн мөн чанарын хэсэг

Гуравдугаар хэсэг: • Дүгнэлтээ дахин харах - Хувийн мөн чанарын онцлогууд

Дөрөвдүгээр хэсэг:

- Дүгнэлтээ дахин харах - Хувийн мөн чанарын давуу талууд/сул талууд ба ажил мэргэжилтэй холбосон хэрэгжүүлэлт

Тавдугаар хэсэг: • Дүгнэлтээ дахин харах - Сонирхол, ажил мэргэжлийн бүлгүүд, авсан оноогоо ойлгох нь

Зургадугаар хэсэг: • Дүгнэлтээ дахин харах - Авьяас чадвар

Долоодугаар хэсэг:

- Дүгнэлтээ дахин харах - Үнэт зүйлс: ажлын орчин нөхцөл, ажлаас хүлээх хүлээлтүүд, амьдралын үнэт зүйлс

Наймдугаар хэсэг: • Сонирхол хэсэгт авсан дээд, доод оноонууд

### Сонсох мэдээлэл #4 - "Ирээдүйн төлөөх ажил хэргийн төлөвлөгөө" (9 минут)

Энэ мэдээлэл нь танд ирээдүйнхээ төлөө хувийн төлөвлөгөө гаргахад тодорхой зааварчилгааг өгнө.

Нэгдүгээр хэсэг: • Ажил хэргийн төлөвлөгөөг хэрхэн гаргах, ажил мэргэжил сонгохдоо үүнийг хэрхэн ашиглах

## Оюутнуудад зориулсан аудио файлууд

### "Ирээдүйд боловсролын тал дээр хийх алхмууд" (17 минут)

Энэ мэдээлэл нь танд ирээдүйнхээ төлөө төлөвлөгөө гаргахад тодорхой заавар өгнө.

**Нэгдүгээр хэсэг:**

- Хэрхэн ажил хэргийн төлөвлөгөөг гаргах, ажил мэргэжлээ сонгоход үүнийг хэрхэн ашиглах

**Хоёрдугаар хэсэг:**

- Коллежийн мэргэжил болон ажил мэргэжлийн замналаа сонгох нь

### "Эцэг эхчүүдэд хандаж хэлсэн үг" (18 минут)

Жич: Эцэг эхчүүдээ – Та бүхэн хүүхдүүдээ зөв чиглүүлэхийн тулд дараах хэсгийг заавал сонсох ёстой.

**Нэгдүгээр хэсэг:**

- Итгэмжит байдал/сайн нярав байх нь мөнгөнөөс илүү чухал

**Хоёрдугаар хэсэг:**

- Оюутан хүнд ажил мэргэжлийн дасгалжуулагч нь болох таны үүрэг